



**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027
И-мэйл: info@fchm.edu.mn

2025.01.02 № 1104
танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/346 тоот тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020-2024 онд хэрэгжүүлэн ажиллах стратеги төлөвлөгөөний 2020-2024 оны хэрэгжилтийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 69 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.БЯМБАСҮРЭН

142250007

ТЭРГҮҮЛЭХ СТРАТЕГИ 1. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

ЗОРИЛГО: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэлхийн жишигт хүргэх чадварлаг хүний нөөцийг хөгжүүлэн, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, боломжоор хангаж, гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан урамшууллын тогтолцоог бий болгох замаар хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж залгамж халааг тасралтгүй бэлтгэхэд оршино.

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ЗОРИЛТ	ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ	ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН, ҮНЭЛГЭЭ
1.Технологид суурилсан хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр	1.1 Технологид дагасан гадаад, дотоод сургалтын шаардлага, хэрэгцээг тодорхойлох	Төлөвлөсөн хэрэгжүүлэх технологийн нэр төрөл, тоонд суурилж сургах эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоо	2021 он Гадаад сургалтад 45 эмч, сувилагч цахимаар болон өөрийн биеэр хамрагдсан. Тус хэсгийн хэрэгжилтийг дүгнэж үзэхэд 2021 онд нийт 45 ажилтан буюу нийт ажилтнуудын 5,46% гадаад сургалтанд цахимаар болон биеэр хамрагдсан 2022 он Нийт 72 эмч, сувилагч, эмнэлгийн гадаад сургалт, хурал семинарт хамрагдсанаас 17 эмч, сувилагч өндөр технологи нэвтрүүлэх сургалтанд, 55 эмч сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд мэргэжлийн чиглэлээр хурал, семинар сургалтанд хамрагдсан байна. 2022 онд нийт ажилтнуудын 8.73 % гадаад сургалтанд хамрагдсан байна. 2023 он Гадаад сургалтын чиглэлээр: 2023 онд нийт 130 ажилтанг гадаад улсад сургалт, хуралд хамруулсан байна. Ажилтнуудын гадаад сургалтыг улсаар нь задалбал Австри улсад-4, Австрали-3, АНУ-7, Араб-2, Казакстан-1, БНСУ-63, Турк-3, БНХАУ-5, Малайз-1, Тайван-19, Тайланд-3, Филиппин-2, Герман-3, Япон улсад-13, Испани-1, Канад улсад-1 ажилтан тус тус гадаад сургалтад хамрагдсан байна. Энэ нь нийт ажилтнуудын 15% болж байна. Дотоод сургалтын чиглэлээр 2023 онд: УНТЭ-ийн ерөнхий захирлын 2023.02.16-ны өдрийн А/51 тоот тушаалаар “УНТЭ-ийн хүний нөөцийн сургалт, хөгжлийн журам”-ыг баталж мөрдөн ажиллаж байна. Журмын дагуу нэвтрүүлж буй технологийн хэрэгцээ шаардлагын дагуу УНТЭ-ийн нийт 55 ажилтанг төгсөлтийн дараах сургалтад хамруулсан. Үүнд: ➢ Төрөлжсөн эмч- 3 /Хэвлийн мэс засал-2, Хэрх үе судлал-1/ ➢ Төрөлжсөн сувилахуй-35 /MRI техникч-1, Ангиографийн техникч-3, Компьютер техникч-3, Мэдээгүйжүүлгийн сувилахуй-8, Мэс заслын сувилахуй-8, Эрчимт эмчилгээний сувилахуй-7, Мэс заслын сувилахуй-4, Чих, хамар, хоолойн сувилахуй-1/

		➤ Дээшлүүлэх эмч-5 /Бөөр шилжүүлэн суулгасны дараах хяналт-4, Гемодиализ судлал-1 ➤ Дээшлүүлэх сувилахуй – 12 /Гемодиализын сувилахуй-3, Мэс заслын сувилахуй, Оношилгооны дурангийн сувилахуй-1 Эрчимт эмчилгээний сувилахуй -1, Яаралтай тусламж судлал-2/ Энэ нь нийт ажилтны 6.5% болж байгаа бөгөөд нийлбэр дүнгээр гадаад дотоод сургалтанд нийт ажилтны 21.5% хамрагдаж мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн байна. 2023 онд эмчилгээ оношилгооны 50 технологи нэвтрүүлсэн байна. <u>2024 он</u> 2024 онд УНТЭ-ийн 64 ажилтнуудыг төгсөлтийн дараах сургалтад хамруулсан. Үүнд: ➤ Төрөлжсөн мэргэжлийн эмч буюу мэс заслын олгох сургалт-12; ➤ Төрөлжсөн мэргэжлийн сувилахуй буюу мэдээгүйжүүлгийн сувилахуй-20, мэс заслын сувилахуй-19, дурангийн сувилахуй-6, сэргээн засахын сувилахуй-1, техникч 6 чиглэлээр нийт 64 сувилагч ; ➤ Дээшлүүлэх чиглэлээр мэдээгүйжүүлгийн мэргэжил дээшлүүлэх-3 эмч, УАУ-ны мэргэжил дээшлүүлэх-2, дурангийн эмчийн мэргэшүүлэх сургалт – 9, чих хамар хоолойн мэргэжил дээшлүүлэх сургалтанд - 4 хүн нийт 18 эмч суралцаж байна. ➤ Мөн магистрийн сургалтанд 21 эмч, докторын сургалтанд 13 эмч хамрагдаж байна. Нийт 64 ажилтан дотоод сургалтанд хамрагдсан нь нийт ажилтнуудын 7.6% байна. Мөн оношилгоо эмчилгээний 67 шинэ технологийг нэвтрүүлсэн байна.
1.2 МУ-д оношлох, эмчлэх боломжгүй болон ховор тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний чиглэлээр өндөр хөгжилтэй орнуудад эмч, сувилагчийн багийг бэлтгэн хөгжүүлэх	Олон улсад бэлтгэгдсэн нарийн мэргэжлийн эмнэлгийн мэргэжилтний тоо	<u>2021-2022 онуудад</u> ➤ БНСУ-д аблаци эмчилгээний чиглэлээр 6 сарын сургалтад 1 эмчийг эмнэлгийн зардлаар сургасан. ➤ Австри Улсад зүрхний өвчин судлалын чиглэлээр 1 сарын сургалтад 1 эмчийг сургасан. ➤ БНТУ-д чөмөг шилжүүлэн суулгах чиглэлээр 3 эмч, сувилагчийг богино хугацаанд сургасан. ➤ Хамтын ажиллагааны хүрээнд Олон улсын сургалт, семинарт явж байгаа эмч нарт цалинтай чөлөө олгодог. Тус онд 72 эмч, сувилагч гадаадад туршлага судалж, сургалт семинарт хамрагдсан

			Тус хэсгийн хэрэгжилтийг дүгнэж үзэхэд 2021 онд нийт эмч сувилагч нарын 20%, 2022 онд 20%-ийг тус бүр гадаад сургалтанд хамруулна гэсэн зорилт тавьсан боловч дэлхий нийтийг хамарсан цар тахлаас шалтгаалан гадаад сургалт хязгаарлагдсан. <u>2023 он</u> 2023 онд нийт 130 ажилтанг гадаад улсад урт богино хугацааны сургалт, хурал, семинарт хамруулсан байна. Ажилтнуудын гадаад сургалтыг улсаар нь задалбал Австри улсад-4, Австрали-3, АНУ-7, Араб-2, Казакстан-1, БНСУ-63, Турк-3, БНХАУ-5, Малайз-1, Тайван-19, Тайланд-3, Филиппин-2, Герман-3, Япон улсад-13, Испани-1, Канад улсад-1 ажилтан тус тус гадаад сургалтад хамрагдсан байна. Энэ нь нийт ажилтнуудын 15% болж байна. Тус хэсгийн хэрэгжилтийг дүгнэж үзэхэд 2023 онд нийт эмч сувилагч нарын 20%-ийг гадаад сургалтанд хамруулна гэсэн зорилт тавьсан боловч 15%-ийг хамруулсан байна. <u>2024 он</u> 2024 онд нийт 165 ажилтанг гадаад улсад сургалт, хуралд хамруулсан бөгөөд 156 ажилтанд <u>цалинтай</u> чөлөөг олгож, 9 ажилтанд <u>цалингүй</u> чөлөөг тухай бүрт тушаалаар олгон суралцуулсан. Ажилтнуудын гадаад сургалтыг улсаар нь задалбал Австри улсад-1, Австрали-4, АНУ-7, Англи-3, Араб-1, Африк-1, Казакстан-3, БНСУ-47, Турк-24, Энэтхэг-4, Индонез-6, БНХАУ-26, Малайз-1, Македоне-1, Тайван-10, Тайланд-1, Герман-5, Словень-1, Сингапур-2, Япон улсад-13, Непал-1, Нидерланд-1, Канад улсад-2 ажилтан тус тус гадаад сургалтад хамрагдсан байна. Тус хэсгийн хэрэгжилтийг дүгнэж үзэхэд 2024 онд нийт эмч сувилагч нарын 30%-ийг гадаад сургалтанд хамруулна гэсэн зорилт тавьсан боловч 16%-ийг хамруулсан байна.
--	--	--	--

	1.3 Олон Улсын мэргэжлийн багтай хамтарсан хөтөлбөр, төсөл, сургалтыг өөрийн эмнэлэгтээ зохион байгуулах	Өөрийн эмнэлэгт олон улсын багтай хамтран зохион байгуулсан болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, сургалтын тоо, нэр төрөл, хамрагдсан хүний тоо	<u>2021 он</u> 1. Тайван Улсын үндэсний их сургуультай хамтран зохион байгуулсан уушги орлуулах ЕСМО аппаратын цахим сургалтад УНТЭ-ийн эрчимт эмчилгээний 11 эмч, 29 сувилагч хамрагдсан. 2. ХБНГУ-ын Ниелс Штэнсэн клиник УНТЭ-ийн Бүдүүн Шулуун гэдэсний мэс заслын тасгийн хамтын ажиллагааны хүрээнд өтгөн задгайрлын үеийн мэс заслын арга техник, мөн консерватив эмчилгээний хувилбаруудын талаар мэдээлэл өгч харилцан ярилцаж, хамтран ажиллаж байна. 3. Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүл мэнд, нийгмийн халамжийн яам хоорондын хамтран ажиллах тохиролцоонд тусгагдсан “Сөүл Төсөл”-ийн хүрээнд зохион байгуулагддаг эмнэлзүйн ээлжит цахим сургалтад 12 эмч хамрагдсан. <u>2022 он</u> 1. Олон улсын Виртуэ сангийн сайн дурын эмч нар монгол улсад ирж, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж, сургалт сургалт зохион байгуулж, туршлага солилцдог. Ажлын байран дээр 9 хоногийн хугацаатай өдөрт 8-10 цаг хамтран ажиллаж 2 кр цагийн сургалтыг зохион байгуулсан. Тус эмнэлгээс нийт 10 эмч, 24 резидент эмч хамрагдсан. Тус төслийн хүрээнд Ховд аймагт НСМЗТ-ийн их эмч Д.Энхзул 14 хоног, Хөвсгөл, Сэлэнг аймагт тус бүр 7 хоног НСМЗТ-ийн эрхлэгч С.энхтуул, Б.Төмөрбаатар, Т.Ундармаа, Д.Тодрол нар тус тус ажиллав. 2. Олон улсын сайн дурын урологийн нийгэмлэгийн эмч нар жил бүр ирж хамтран мэс засал, ажлын байрны сургалт зохион байгуулдаг. Энэ жил 10 дахь жилдээ ажлын байран дээр сургалтыг зохион байгуулж 10 их эмч, 7 резидент эмч сургалтанд хамрагдсан. 3. Эмч, сувилагчдыг чадавхижуулах зорилгоор гадны профессорын сургалтыг нийт 16 удаа зохион байгуулсан бөгөөд БНХАУ, БНСУ, Канад, Тайвань, Франц, Турк, ХБНГУ, Япон, АНУ зэрэг улсаас эрхтэн шилжүүлэн суулгах, зүрхний хэм алдагдал, мэдрэл, нүд, чих хамар хоолой, үе, урологи, проктологи, уушгины дуран, халдвар судлал, лабораторийн чиглэлээр хүрэлцэн ирж сургалт хийсэн6 4. 2022 онд УНТЭ-ийн Нүд судлал, мэс заслын тасагт “ORBIS INTERNATIONAL” олон улсын байгууллагын 12.000\$ санхүүжилт, дэмжлэгтэй хэрэгжсэн “Монгол Улсад нүд судлалын
--	---	---	--

		салбарт сургалтын шинэлэг загварыг бий болгох нь” төслийг хэрэгжүүлсэн. <u>2023 он</u> 2023 онд БНСУ, БНТУ, БНХАУ, Бельги, ХБНГУ, АНУ, Энэтхэг, Тайвань, Япон, Австрали, Бүгд Найрамдах Гүрж улс зэрэг 17 орны эмч нарын баг бүрэлдэхүүн УНТЭ-т хүрэлцэн бөөр, бөөрний мэс засал, диализ, бүдүүн шулуун гэдэсний мэс засал, эрхтэн шилжүүлэн суулгах, гастроэнтерологи, нүд судлал, чих хамар хоолой судлал, ерөнхий мэс засал, мэдрэлийн болон мэдрэлийн мэс засал, зүрх судасны мэс засал, зүрхний хэм алдагдал, цусны эмгэг судлал, чөмөг шилжүүлэн суулгах, дотоод шүүрэл, уушги, харшил судлалын чиглэлээр ажлын байрны сургалт, семинар зохион байгуулж 150 гаруй эмч мэргэжилтнүүд хамрагдсан. Энэ нь нийт ажилтнуудын 18% болж байна. Тус хэсгийн хэрэгжилтийг дүгнэж үзэхэд 2023 онд нийт эмч сувилагч нарын 20%-ийг гадаад сургалтанд хамруулна гэсэн зорилт тавьсан бөгөөд 18%-ийг хамруулсан байна. <u>2024 он</u> 2024 Чих, хамар, хоолой мэс заслын тасгаас дүлийрэлт сонсгол бууралтаас сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хүрээнд үгийн аудиометрийн шинжилгээг Монгол улсад хөгжүүлэх төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Тус төсөл нь БНСУ-ын КОИКА олон улсын хамтын ажиллагааны байгуулага, Рафаел интернешнл ТББ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа бөгөөд УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ЭМЖЖ эмнэлгүүдийн сонсгол судлалын эмч нарт сонсголын аппаратыг тохируулга хийх ажлын байрны сургалт, үгийн шинжилгээний талаар сургалтууд үргэлжлэн хийгдсэн. Сургуулийн насны сурагчдын дунд сонсгол бууралтын тархалтыг илрүүлэх судалгаа хийж ЕБС-ийн 2, 40, 57, Ирээдүй монгол нийт 4 сургуулийн 594 сурагч хамрагдсанаас сонсголын бууралт 13.5%-тай буюу 77 хүүхдэд илэрсэн. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
		<u>2021-2022 он</u> ➤ Зүрхний төвд аблаци эмчилгээг хөгжүүлэх зорилгоор Зүрхний төвийн их эмч Г.Анандыг БНСУ-д 6 сарын сургалтад хамруулсан. ➤ Зүрх судасны мэс заслын эмч нар 2020 оны 11 сараас 2021 оны 5-р сар хүртэл УГТЭ-т ажлын байрны сургалтанд хамрагдсан. <u>2023 он</u> Зүрхний төвөөс дараах эмч нар сургалтанд хамрагдсан.

	1.4 Монгол улсад нутагшиж буй шинэ технологийг өргөжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэн, хөгжүүлэх	Зүрхний эмнэлзүйн төвийн хүний нөөцийг бүрдүүлж, мэргэшүүлж хөгжүүлсэн байх	1. Зүрхний төвийн их эмч Э.Баттөр Япон Улсын Токушукай эмнэлэгт туршлага судлах сургалтанд 2. Зүрхний төвийн их эмч Б.Бум-Эрдэнэ Тайван улсад мэргэжлийн чиглэлийн сургалтанд 3. Зүрхний төвийн их эмч Г.Ананд Тайван улсад мэргэжлийн чиглэлийн сургалтанд 4. Зүрхний төвийн их эмч Э.Баттөр Япон улсад мэргэжлийн чиглэлээр олон улсын хуралд оролцсон 5. Зүрхний төвийн их эмч Б.Тайхар БНСУ-ын эрүүл мэндийн сангийн хөтөлбөрт тэнцэж Сөүлийн үндэсний их сургуулийн эмнэлэгт зүрхний ангиографийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх чиглэлээр тус тус сургалтад хамрагдсан Зүрхний болон мэдрэлийн судсан дотуурх эмчилгээ, мэс заслын эмчилгээг өргөжүүлэх чиглэлээр дүрс оношлогооны техникч, сувилагч нарыг гадаад улсад мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан байна. 1. П.Мөнхбаатар ДОТ техникч Тайвань улсад 2. Б.Болорцэцэг ДОТ техникч Тайвань Улсын Три-Сервис Нэгдсэн Эмнэлэгт ангиографийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад 3. Э.Билгүүн ДОТ техникч Тайвань Улсын Три-Сервис Нэгдсэн эмнэлэгт ангиографийн чиглэлээр тус тус мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан. 2024 он 1. УНТЭ-ийн Зүрхний Төвийн зүрх судасны мэс заслын эмч О.Золбоо Тайвань улсын Tri-Service General Hospital эмнэлэгт 3 сарын хугацаатай Зүрх судасны мэс заслын чиглэлээр сургалтанд хамрагдсан. Мөн Тайвань улсад зохион байгуулагдсан “International centrimag workshop 2024” олон улсын хуралд оролцсон. 2. УНТЭ-ийн Зүрхний Төвийн сувилагч М.Золзаяа Тайвань улсын Цэргийн нэгдсэн эмнэлэгт 1 сарын хугацаатай сувилахуйн чиглэлээр сургалтанд хамрагдсан. 3. УНТЭ-ийн Зүрхний Төвийн зүрх судасны мэс заслын эмч Ч.Мандахнар, кардиологи эмч М.Буянбаатар нар нь Тайвань улсын Tri-Service General Hospital эмнэлэгт 3 сарын хугацаатай тус тус сургалтанд хамрагдсан.
--	--	--	---

			4. УНТЭ-ийн Зүрхний Төвийн зүрх судасны мэс заслын эмч А.Ганцэцэг Серб улсад зохион байгуулагдсан “Пейсмекер гардан хийх” сургалтанд хамрагдсан. 5. Монгол Улсад нутагшиж буй технологийг өргөжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэн Hybride хэлбэрээр хөгжүүлэх зорилтын хүрээнд Зүрхний АВ зангилааны хориг, синусийн зангилааны сулралын хам шинжийн үед пейсмекер суулгац эмчилгээ хийх 3 багийг УГТЭ-ийн зөвлөх эмч Ц.Саруул эмчийн удирдлаганд бэлтгэж байна. Үүнд: Зүрхний төвийн их эмч Э.Баттөр, О.Золбоо нар захын болон зүрхний судасны ангио, зүрхний эхо пейсмекер эмчилгээ; их эмч Ч.Мандахнар - захын судасны ангио, зүрхний эхо, пейсмекер эмчилгээ; М.Буянбаатар - зүрхний ангио, зүрхний улаан хоолойн эхо, пейсмекер, аблаци; Б.Бум-Эрдэнэ - пейсмекер, аблаци, захын судасны ангио; А.Бумбаяр – пейсмекер эмчилгээ, EGM, аблаци эмчилгээгээр тус тус бэлтгэгдэж байна. 6. 2024 оны 05 сарын 01-ээс Зүрхний төв нь гурвалсан гэрээ байгуулан ШУГТЭ-ийн зүрхний хэм судлалын эмч, Анагаах ухааны доктор, тэргүүлэх зэргийн эмч, дэд профессор Ц.Саруул эмчийг зөвлөх эмчээр ажиллуулан 2024 онд байнгын пейсмекер суулгац эмчилгээг нийт 65 хүнд амжилттай хийсэн.
		Мэдрэлийн эмнэлзүйн төвийн мэс заслын хүний нөөцийг бүрдүүлж, мэргэшүүлж хөгжүүлсэн байх	Тайлант хугацааны хэрэгжилт 100% <u>2021-2022 он</u> 1. Мэдрэлийн мэс заслын тусламж үйлчилгээг өргөжүүлэх, хөгжүүлэх зорилгоор байгууллагын бодлогоор мэдрэлийн мэс заслын 2 эмчийг ажилд авсан. 2. МЭТ-ийн их эмч С.Алтан-очир, Б.Тулга нар БНСУ-д зохион байгуулагдах азийн нурууны мэс заслын 13 дахь конференцид оролцохтой холбоотой 5 хоногийн цалинтай чөлөө олгосон. 3. УГТЭ-т мэргэжил дээшлүүлэх сургалтад 6 сарын хугацаатай сургалтад Б.Хадбаатар, их эмч Б.Энхзориг 10 сарын хугацаатай тус тус сургалтад хамрагдсан. <u>2023он</u> Мэдрэлийн эмнэлзүйн төвөөс дараах эмч нар сургалтанд хамрагдсан.

		4. Мэдрэлийн эмнэлзүйн төвийн мэдрэлийн мэс заслын эмч М.Золбоо БНСУ-д суралцсан 5. Мэдрэлийн эмнэлзүйн төвийн мэдрэлийн эмч Б.Энхзориг Малайз улсад зохион байгуулагдах ЭМЯ, МУ дахь НҮБ-ийн хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлж буй Харвардын их сургуулийн "Эрүүл мэндийн салбар дахь манлайлал сэдэвт сургалтад хамрагдах болсон учир 6. Мэдрэлийн эмнэлзүйн төвийн мэдрэлийн мэс заслын эмч Г.Баттулга БНСУ-ын Суван хотын Вильтцийн нэрэмжит эмнэлэгт мэдрэлийн мэс заслын чиглэлээр 7. Мэдрэлийн эмнэлзүйн төвийн мэдрэлийн мэс заслын эмч Б.Тулга БНСУ-ын Суван хотын Вильтцийн нэрэмжит эмнэлэгт мэдрэлийн мэс заслын чиглэлээр 8. Мэдрэлийн эмнэлзүйн төвийн мэдрэлийн мэс заслын эмч С.Алтан-Очир мэргэжил дээшлүүлэх чиглэлээр Япон улсад сургалтад тус тус хамрагдсан байна. <u>2024 он</u> 9. Мэдрэлийн мэс заслын эмч С.Алтан-Очир нь 2023 оны 12 сараас 2024 оны 03 сард Япон Улсын Жичи их сургуулийн эмнэлэг ба Шизүока институтэд “Эпилепси судлал”, “Эпилепсийн мэс засал” чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан. 10. Нейроангиологийн эмч Б.Хадбаатар 2024.09.08-11.08ны хооронд Япон Улсын Тораномон эмнэлэгт судсан дотуурх мэс заслын тасагт мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан. 11. 2024 оны жилийн эцсийн байдлаар Мэдрэлийн эмнэлзүйн төвд нийт 4 мэдрэлийн мэс засалч эмч ажиллаж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	Уушги харшлын төвийн хүний нөөцийг бүрдүүлж, мэргэшүүлж хөгжүүлсэн байх	<u>2021-2022 он</u> ➤ УХСТ-ийн эмч Б.Далай Зальцбургийн олон улсын семинарт 2021.01.12-15-ны хооронд оролцож, эмнэлзүйн тохиолдол хэлэлцүүлэн, шилдэг эмнэлзүйн тохиолдлоор шалгарч, уг тохиолдлын танилцуулга онлайн номын санд байршсан. ➤ Монголын Уушгины нийгэмлэг, Тайваны их сургуулийн эмнэлэгтэй хамтарсан зохион байгуулагдсан 2 өдрийн олон улсын сургалтанд УНТЭ-ийн Уушиг, харшил судлалын төвийн эмч нарыг бүрэн хамруулсан.

			➤ УНТЭ-ийн УХСТ, Монголын Уушгины нийгэмлэгтэй хамтран “Уушгины Архаг Бөглөрөлт өвчний оношилгоо эмчилгээ” сэдэвт сургалтыг хот хөдөөгийн дотрын 120 эмч нарт зориулж 2021.01.23-нд зохион байгуулсан. ➤ 7 хоног бүр Уушгины эмч нарын журнал клубыг зохион байгуулж хэвшсэн. ➤ УНТЭ-ийн УХСТ, АШУҮИС-ийн УХСТэнхэмтэй хамтран “Ковид-19 өвчтөний менежмент” сэдвээр нийт эмч нарт цахим сургалтыг 2021.05.15-нд зохион байгуулсан. ➤ АШУҮИС-ийн эрдмийн чуулганд “Олон эрхтэн хамарсан саркойдозын тохиолдол” сэдэвт эмнэлзүйн ховор тохиолдол хэлэлцүүлж, Эрүүл мэндийн шинжлэх ухаан сэтгүүлд хэвлүүлсэн. ➤ УНТЭ-ийн “Эрдмийн чуулган-42” “Анафилаксийн тохиолдлууд” сэдэвт судалгааны ажил хийж оролцсон ➤ УХСТ-ийн эмч, мэргэжилтнүүдийн мэдлэгийг дээшлүүлэхэд чөлөөг олгон дэмжин ажиллав. Их эмч Б.Далай БНСУ-д 10 хоногийн хугацаатай, их эмч Ц.Батцэнгэл 6 хоногийн хугацаатай ОХУ-д, дарга Б.Одончимэг ОХУ-н Улаан Үд хотод хурал, семинарт тус тус оролцов. ➤ Тайвань улсад УХСТ-ийн эрхлэгч Б.Одончимэг, их эмч Г.Анхболд, сувилагч Т.Ариунаа 2022.11.14-2022.11.25 хугацаанд 9 хоногийн сургалтанд хамрагдсан. <u>2023 он</u> Уушги харшлын төвийн дараах эмч нар сургалтанд хамрагдсан. ➤ Уушги, харшил судлалын төвийн их эмч Б.Далай Австри улсад мэргэжлийн чиглэлээр олон улсын хуралд оролцох ➤ Уушги, харшил судлалын төвийн их эмч Г.Анхболд БНСУ-д суралцах болсон тул ➤ Уушги, харшил судлалын төвийн их эмч Н.Даваажав БНСУ-ын эрүүл мэндийн сангийн хөтөлбөрт тэнцэж Сөүлийн үндэсний их сургуулийн эмнэлэгт уушигны дурангийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан ➤ Уушги, харшил судлалын төвийн их эмч Д.Содгэрэл БНСУ-д зохион байгуулагдах "Эрүүл мэндийн салбарын менежерүүдийн чадавхийг дээшлүүлэх, удирдлага зохион байгуулалт, эмнэлгийн чанарын менежмент" сэдэвт сургалтад тус тус хамрагдсан байна.
--	--	--	---

			<u>2024 онд</u> ➤ Уушги, харшил судлалын төвийн их эмч Б.Далай 2024.11.01-12.01-ний өдрүүдэд Америкийн засгийн газрын хөтөлбөрөөр Австрийн их сургуулийн эмнэлэгт 1 сарын хугацаатай ➤ Уушги, харшил судлалын төвийн их эмч Ц.Цэлмэг, Н.Даваажав нар 2024.11.15-18-ны өдрүүдэд Ази номхон далайн уушгины нийгэмлэгийн хуралд оролцсон ➤ Уушги, харшил судлалын төвийн дарга, их эмч Б.Одончимэг 2024.10.27-11.15-ныг хүртэл Япон Улсын NCGM эмнэлэг дээр уушгины дурангийн сургалтанд ➤ Уушги, харшил судлалын төвийн их эмч Д.Содгэрэл, Н.Даваажав, сувилагч Т.Ариунаа нар 2024.12.08-12.27-ныг хүртэл Япон Улсын NCGM эмнэлэгт уушгины дурангийн сургалтанд тус тус хамрагдсан. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
		Бусад тасаг, төв, нэгжийн өргөтгөл, шинэчлэл, шинэ технологийг дагасан хүний нөөцийг бүрдүүлж, мэргэшүүлж хөгжүүлсэн байх	<u>2021-2022 он</u> Шинэ технологийг дагасан хүний нөөцийг дараах байдлаар бүрдүүлж, мэргэшүүлэн хөгжүүлж байна. Үүнд: ➤ Эмч, сувилагчдыг чадавхижуулах зорилгоор гадны профессорын сургалтыг нийт 16 удаа авсан бөгөөд эдгээр нь БНХАУ, БНСУ, Канад, Тайвань, Франц, Турк, ХБНГУ, Япон, АНУ зэрэг улсаас эрхтэн шилжүүлэн суулгах, зүрхний хэм алдагдал, мэдрэл, нүд, чих хамар хоолой, үе, урологи, проктологи, уушгины дуран, халдвар судлал, лабораторийн чиглэлээр хүрэлцэн ирж сургалт хийсэн. ➤ Хамтын ажиллагааны хүрээнд Олон улсын сургалт, семинарт явж байгаа эмч нарт цалинтай болон цалингүй чөлөө олгон дэмжин ажиллаж байна. ➤ БНСУ, БНТУ, Тайвань зэрэг улсын 20 орчим эмнэлэгтэй сургалт зохион байгуулах, туршлага солилцох, Монгол улсад эмчлэгдэх боломжгүй өвчтөнд зөвлөгөө авах, тухайн хамтын ажиллагаатай байгууллага руу илгээх зэрэг ажлын хүрээнд шинээр хамтран ойлголцлын санамж бичгүүдэд Ерөнхий захирал гарын үсэг зурсан. ➤ ЭМЯ-ЭМХТ хамтран зохион байгуулдаг эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалтад эмч, сувилагч нараа цаг тухай бүрт хамруулж байна. 2022 онд 10 их эмч, 7 сувилагч багшийг бэлтгэн сургахаар төлөвлөсөн бөгөөд ЭМЯ, ЭМХТ, Жайка олон улсын байгууллага хамтран зохион байгуулдаг Эмнэлзүйн чиглүүлэгч багш бэлтгэх сургалтанд 6 их эмч 7 сувилагчийн хамруулсан.

		➤ УНТЭ нь 7 үндэсний чиглүүлэх багштай бөгөөд дотоодын эмнэлзүйн сургагч багш нараа чадавхижуулах сургалтыг зохион байгуулдаг болно. ➤ Ажилтнуудыг магистр, докторын зэрэг хамгаалах үед хамгаалах үед дэмжлэг үзүүлэн тухай бүрт 14-30 хоногийн хугацаатай цалинтай чөлөө олгон ажиллаж байна. ➤ 2022 онд төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд УНТЭ-ээс 10 их эмч, 18 сувилагч суралцсан байна. ➤ АШУҮИС-д магистрантур болон докторантурын сургалтад суралцаж буй ажилтнуудыг дэмжин 2021 онд 7 докторантур, 8 магистрантурын, 2022 онд шинээр элссэн 4 докторантур, 7-н магистрантурын төлбөрийн 30%-ийг хөнгөлүүлэхээр хамтран ажиллаж байна. Эмнэлгийн хэмжээнд нийт ажилтнуудын ажлын байран дахь сургалт, мэргэшүүлэх сургалт, туршлага солилцох арга хэмжээ, болон бусад сургалтуудыг нийт давхардсан тоогоор 232 удаа зохион байгуулж, 4463 ажилтан хамрагдсан байна. <u>2023 он</u> Шинэ технологийг дагасан хүний нөөцийг дараах байдлаар бүрдүүлж, мэргэшүүлэн хөгжүүлж байна. Үүнд: ➤ Эмч, сувилагчдыг чадавхижуулах зорилгоор гадны профессорын сургалтыг нийт 17 удаа авсан бөгөөд эдгээр нь БНХАУ, БНСУ, Канад, Тайвань, Франц, Турк, ХБНГУ, Япон, АНУ зэрэг улсаас эрхтэн шилжүүлэн суулгах, зүрхний хэм алдагдал, мэдрэл, нүд, чих хамар хоолой, үе, урологи, проктологи, уушгины дуран, халдвар судлал, лабораторийн чиглэлээр хүрэлцэн ирж сургалт хийсэн. ➤ Хамтын ажиллагааны хүрээнд Олон улсын сургалт, семинарт явж байгаа 130 гаруй эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтнүүдэд цалинтай болон цалингүй чөлөө олгон дэмжин ажилласан. ➤ УНТЭ нь сүүлийн жилүүдэд БНСУ, БНТУ, Тайвань, БНХАУ, АНУ зэрэг улсын 22 эмнэлэгтэй сургалт зохион байгуулах, туршлага солилцох, Монгол улсад эмчлэгдэх боломжгүй өвчтөнд зөвлөгөө авах, тухайн хамтын ажиллагаатай байгууллага руу илгээх зэргээр хамтын ажиллагааны гэрээтэй байсан бөгөөд 2023 онд дахин 15 эмнэлгүүдтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Нийт 37 эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагатай хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж байна.
--	--	--

			➤ ЭМЯ-ЭМХТ хамтран зохион байгуулдаг эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалтад 2023 онд 2 их эмч, 4 сувилагч хамрагдсан бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт сургагч их эмч 81, сургагч сувилагч 22 ажиллаж байна. ➤ Ажилтнуудыг магистр, докторын зэрэг хамгаалах үед хамгаалах үед дэмжлэг үзүүлэн тухай бүрт 14-30 хоногийн хугацаатай цалинтай чөлөө олгон ажиллаж байна. ➤ 2023 онд төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд УНТЭ-ээс 55 их эмч, сувилагч суралцаж байна. 2020-2023 оны жил бүрийн хэрэгжилт 15-20 хувьтай буюу зорьсон түвшиндээ хүрсэн байна. <u>2024 он</u> ➤ 2024 оны туршид СЭШХАА нь нийт 23 удаа гадаадын өндөр хөгжилтэй орнуудаас зочин профессор урьж ажиллуулсан. ➤ УНТЭ нь 2023-2024 онуудад дараах олон улсын эмнэлгүүдтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж хамтран ажиллаж байна. Үүнд: 1. Канадын Laurel Surgical Foundation 2. Энэтхэг улсын LV Parsad Eye hospital, Маренго эмнэлэг 3. Турк улсын Хисар Континентал эмнэлэг, Медикал парк эмнэлэг, Дуньягоз эмнэлэг, Аж бадем эмнэлэг 4. БНСУ-ын Самсунг Эрүүл мэндийн төв, Поханг СМ Христийн эмнэлэг, Эйн эмнэлэг, Донг-А эмнэлэг 5. Тайванийн Үндэсний ИС-н эмнэлэг, Цэргийн гурвалсан үйлчилгээт эмнэлэг, Маккей нэрэмжит ИС-н эмнэлэг 6. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Олон Улсын Монгол эмнэлэг, ӨМ-ийн Шил гол аймгийн эмнэлэг, Шинжиангны АУИС-ийн 1-р эмнэлэг, Жөжианг ИС-ийн 2-р эмнэлэг ➤ 2024 онд нийт 165 ажилтанг гадаад улсад сургалт, хуралд хамруулсан бөгөөд 156 ажилтанд цалинтай чөлөөг олгож, 9 ажилтанд цалингүй чөлөөг тухай бүрт тушаалаар олгон суралцуулсан. Ажилтнуудын гадаад сургалтыг улсаар нь задалбал Австри улсад-1, Австрали-4, АНУ-7, Англи-3, Араб-1, Африк-1, Казакстан-3, БНСУ-47, Турк-24, Энэтхэг-4, Индонез-6, БНХАУ-26, Малайз-1, Македоне-1, Тайван-10, Тайланд-1, Герман-5, Словень-1, Сингапур-2, Япон улсад-13, Непал-1,
--	--	--	--

			Нидерланд-1, Канад улсад-2 ажилтан тус тус гадаад сургалтад хамрагдсан байна. ➤ Мөн 64 ажилтан дотоод сургалт буюу мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулсан. ➤ Нийт оношилгоо эмчилгээний 67 шинэ технологийг нэвтрүүлсэн байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
2.Ажилчдын ур чадварыг хөгжүүлэх хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр	2.1 Ажлын байранд тохирсон ажилтны ур чадварыг “Ур чадварын матриц”-аар үнэлэх	Нийт ажлын байрны “Ур чадварын матриц”-ын үнэлгээ	2024 онд Захиргаа, хүний нөөцийн албанаас Төрийн албан хаагчийн маягтад тусгагдсан ур чадвар, албан тушаалын тодорхойлолтын дагуу тухайн ажлын байрны ур чадварт нийцүүлэн 5 чадамжийг үнэлэх үнэлгээний хуудсыг боловсруулан ажилтнуудаас чадамжийн үнэлгээг авч үнэлж эхэлсэн. Эмч, эмнэлгийн мэргэжилтний чадамжийн үнэлгээг боловсруулахад УНТЭ-ийн ерөнхий захирлын 2023.09.04-ний өдрийн А/232 тушаалаар батлагдсан "УНТЭ-ийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд мөрдөж ажиллах стандарт, заавар, удирдамж, үйлдлийн технологийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай" тушаал, УНТЭ-ийн ерөнхий захирлын 2024.12.13-ны өдрийн А/402 тушаалаар баталсан "Амбулаториор хийгдэх мэс ажилбарын жагсаалт батлах тухай" тушаалыг үндэслэл болгох бөгөөд цаашид мэргэшсэн байдал, мэдлэг, ур чадварт үндэслэн гүйцэтгэлээр урамшуулал олгохоор тооцоолон ажиллаж байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2019.01.09-ний өдрийн 05 дугаар тогтоолыг үндэслэн Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын 2020.04.02-ны өдрийн А/138 тоот тушаалаар "УНТЭ-ийн ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг дүгнэх, улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%

	2.2 Ажилтан бүрийн “Ур чадварын матриц”-д нийцсэн ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэх	“Ур чадварын матриц”-д нийцсэн, шинэчлэгдсэн ажлын байрны тодорхойлолт	2021-2024он - УНТЭ-ийн Захиргаа, хүний нөөцийн алба нь албан тушаалын тодорхойлолт боловсруулахад аргазүйн зөвлөгөө авах, мэргэжилтэн томилуулах, хамтран ажиллах хүсэлтийг Төрийн албаны зөвлөлд 2024.11.04-ний 5/1736 тоот албан бичгээр хүргүүлсэн болно. 2024.11.25-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын дарга Д.Нармандах “Байгууллагын чиг үүрэг, ажлын байрны шинжилгээ хийх, албан тушаалын тодорхойлолт боловсруулах аргачлал” сэдвээр УНТЭ-ийн удирдах ажилтнуудад сургалтыг зохион байгуулсан. Төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдэд жишиг болохуйц албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажилд Төрийн албаны зөвлөлөөс зөвлөн тусалж дэмжлэг үзүүлж ажиллахаар санал зөвшилцсон болно. - УНТЭ-ийн Захиргаа, хүний нөөцийн алба нь 111 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахаар тасаг, нэгжүүдээс албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах эсэх асуудлаар санал авч байна. “Албан тушаалын тодорхойлолт /ажлын байр/-ыг шинэчлэн боловсруулах 22 ажилтны бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийг ерөнхий захирлын 2024.11.25-ны өдрийн А/371 тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийг Захиргаа, хүний нөөцийн албаны дарга П.Мөнхтуул ахлан ажиллаж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	2.3 Ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан шаардлагуудад нийцүүлэн бэлтгэж, хөгжүүлэх	Ажлын байрны шаардлага хангаж бэлтгэгдсэн ажилтны тоо	Улсын Нэгдүгээр Төв эмнэлэг 2020 оны 01 дүгээр сард Төлөөлөн удирдах зөвлөлтэй болсноор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020.05.29-ний өдрийн 07 тоот “Улсын нэгдүгээр төв эмнэлгийн бүтэц, орон тоо, стратеги төлөвлөгөө батлах тухай” тогтоолоор бүтцийг шинэчлэн баталсан. Захиргаа, хүний нөөцийн алба нь жил бүр тус тогтоолын дагуу бүтэц, орон тоо, шилжилт хөдөлгөөн, цалингийн тушаалыг шинэчлэн баталдаг. Үүнд: - УНТЭ-ийн ерөнхий захирлын 2020.10.16-ны өдрийн А/390 тоот “Байгууллагын бүтэц шинэчлэгдэн батлагдсантай холбоотой зарим алба, төв, тасгийн болон албан тушаал, ажлын байрны нэршилд өөрчлөлт оруулах, ажилтнуудыг ажлаас чөлөөлөх, ажилд томилох, цалинг батлах тухай” тушаалыг баталж мөрдөн ажилласан. - УНТЭ-ийн ерөнхий захирлын 2021.01.22-ны өдрийн А/16 тоот “УНТЭ-ийн албан тушаалын жагсаалт, мөрдөгдөх цалингийн жишиг, зэрэглэл, ажилтнуудыг шилжүүлэн томилох, ажилтнуудын цалингийн төсөв, гүйцэтгэлийг батлах тухай”

			тушаалыг тус тус үндэслэн 32 албан тушаал, ажлын байр шинээр нэмэгдсэн бөгөөд албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан. 3. УНТЭ-ийн ерөнхий захирлын 2022.01.20-ны өдрийн А/21 тоот тушаалаар “УНТЭ-т 2022 онд мөрдөгдөх цалингийн сүлжээ, нийт ажилтнуудын цалингийн төсөв, гүйцэтгэл”-ийг баталсан. 2022.12.02-ны өдрийн байдлаар нийт 839 ажилтан ажилласнаас удирдах албан тушаалтан 13, их эмч 210, сувилагч 286, тусгай мэргэжилтэн 96, бусад ажилтан 234, гэрээт ажилтан 12 байна. 4. УНТЭ-ийн ерөнхий захирлын 2023.01.02-ны өдрийн А/01 тушаалаар “Албан тушаалын цалингийн доод хэмжээг тогтоох, ажилтнуудын цалин хөлс”-ийг шинэчлэн баталсан. 2023.12.30-ны өдрийн байдлаар нийт 874 ажилтан ажилласнаас удирдах албан тушаалтан 13, их эмч 213, сувилагч 295, тусгай мэргэжилтэн 93, бусад ажилтан 241, гэрээт ажилтан 19 ажилтан байна. 5. УНТЭ-ийн ерөнхий захирлын 2024.03.01-ний А/70 тушаалаар “УНТЭ-ийн албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн доод хэмжээ, ажилтнуудын цалин хөлс”-ийг шинэчлэн баталсан. 2024.12.21-ний өдрийн байдлаар нийт 868 ажилтан ажиллаж байгаа бөгөөд үндсэн орон тооны 842, гэрээт 22 ажилтан байна. Үндсэн орон тооны ажилтныг задалбал удирдах 13, их эмч 215, сувилагч 300, тусгай мэргэжилтэн 96, бусад ажилтан 222 байна. Дээрх тушаалын дагуу албан тушаалын тодорхойлолтыг тухай бүрд боловсруулан батлуулж, ажлын байрны шаардлагад нийцсэн эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	2.4 Эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн үр чадварын ахлах зэргийг 11%-иар, тэргүүлэх зэргийг 7.3%-иар, зөвлөх зэргийг 3.5%-иар тус тус нэмэгдүүлэх	Мэргэжлийн ахлах зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтний тоо	Тайлант хугацааны эцэст буюу 2024 оны 12 сарын 01-ний өдрийн байдлаар нийт 149 ахлах зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байгаа бөгөөд энэ нь нийт ажилтны 17.6%-ийг эзэлж байна. 2023 онд ахлах зэрэгтэй 131 эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байсан бөгөөд энэ нь нийт ажилтны 15.5%-хувийг эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад ахлах зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтний тоо 2.1%-аар нэмэгдсэн байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
		Мэргэжлийн тэргүүлэх зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтний тоо	Тайлант хугацааны эцэст буюу 2024 оны 12 сарын 01-ний өдрийн байдлаар нийт 148 тэргүүлэх зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байгаа бөгөөд энэ нь нийт ажилтны 17.5% хувийг эзэлж байна. 2023 онд тэргүүлэх зэрэгтэй 146 эмнэлгийн мэргэжилтэн

			ажиллаж байсан бөгөөд энэ нь нийт эмнэлгийн мэргэжилтний 17.3%-ийг эзэлж өмнөх онтой харьцуулахад 0.2%-аар нэмэгдсэн байна. Энэ нь тэргүүлэх зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтнүүд харьцангуй тогтвортой ажиллаж байгааг харуулж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
		Мэргэжлийн зөвлөх зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтний тоо	Тайлант хугацааны эцэст буюу 2024 оны 12 сарын 01-ний өдрийн байдлаар нийт 42 зөвлөх зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байсан нь нийт ажилтны 4.9%-ийг эзэлж байна. 2023 онд зөвлөх зэрэгтэй 43 эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байсан бөгөөд энэ нь нийт ажилтны 5.1%-ийг эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад 0.2%-аар буурсан ба шалтгаан нь 2024 онд зөвлөх зэрэгтэй 4 ажилтан өндөр насны тэтгэвэрт гарсан болно. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
3.Хувь хүний хөгжлийн хөтөлбөр	3.1 Боловсролын зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтний тоог нэмэгдүүлэх	Магистрийн зэрэг хамгаалсан эмч мэргэжилтний тоог 30%-иар нэмэгдүүлж, нийт эмч нарын 70,4% нь магистрийн зэрэгтэй байна.	2023 оны байдлаар эмнэлэгт үндсэн орон тооны 213 их эмч ажиллаж байгаагаас магистрын зэрэгтэй 115 их эмч ажиллаж байна. 2024 онд 215 эмч үндсэн орон тоонд ажиллаж байгаа бөгөөд 4 эмч магистрын зэрэг хамгаалж нийт 119 магистрын зэрэгтэй эмч ажиллаж байгаа нь эмч нарын 55.3%-ийг эзэлж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 55 хувьтай буюу зорилтот түвшиндээ хараахан хүрээгүй байна.
		Магистрийн зэрэг хамгаалсан сувилагч, тусгай мэргэжилтний тоог 16.1%-иар нэмэгдүүлж, нийт сувилагч, тусгай мэргэжилтний 20% нь магистр зэрэгтэй байна.	2024 оны байдлаар эмнэлэгт нийт сувилагч-300, тусгай мэргэжилтэн-96 ажиллаж байна. Боловсролын зэргээр нь авч үзвэл ➤ дипломын боловсролтой сувилагч-70 /өмнөх оноос 8-аар нэмэгдсэн/ ➤ дипломын зэрэгтэй тусгай мэргэжилтэн-43 ➤ бакалаврын боловсролтой сувилагч-196 /өмнөх оноос 6-аар нэмэгдсэн/ ➤ бакалаврын боловсролтой тусгай мэргэжилтэн 7 ➤ магистр зэрэгтэй 26 сувилагч тус тус ажиллаж байна. Энэ нь нийт сувилагч, тусгай мэргэжилтний 6.5 хувийг эзэлж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 6.5 хувьтай буюу зорилтот түвшиндээ хараахан хүрээгүй байна. Энэ нь сувилахуйн хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн болон сувилагч, тусгай мэргэжилтний хомсдолтой холбоотой байна.

		Докторын зэрэг хамгаалсан эмч мэргэжилтний тоог 10%-иар нэмэгдүүлж, нийт эмч нарын 19.8% нь докторын зэрэг хамгаалсан байна.	2024 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар эмнэлэгт 215 эмч ажиллаж байгаагаас Шинжлэх ухааны доктор 1, АУ-ны доктор 16, профессор цолтой 1 их эмч ажиллаж байна. Энэ нь нийт эмч нарын 8 хувийг эзэлж байна. 2024 онд 13 их эмч докторантад суралцаж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 8% буюу зорилтот түвшиндээ хүрээгүй байна.
		Нийт сувилагч, тусгай мэргэжилтний 1% нь докторын зэрэг хамгаалсан байна	УНТЭ-т ажиллаж буй сувилагч, тусгай мэргэжилтнээс 2024 оны жилийн эцсийн байдлаар докторын зэрэг хамгаалсан сувилагч, тусгай мэргэжилтэн байхгүй байна. Тайлант хугацааны хэрэгжилт 0% буюу зорилтот түвшиндээ хүрээгүй байна.
	3.2 Эмнэлгийн ажилтнуудын харилцаа хандлага, ёс суртахууныг сайжруулах /94,5%-д хүргэнэ./	Ажилтнуудын харилцаа, хандлага, ёс суртахууны зөрчлийн тоо 30%-иар буурсан байх	УНТЭ-ийн ёсзүйн салбар хороо нь тайлант хугацаанд захиргаа, хүний нөөцийн алба болон бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран жилдээ 15-18 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 1650-1700 эмч, 1700 орчим эмнэлгийн мэргэжилтэн, 600 орчим дэмжих үйлчилгээний ажилтнуудыг хамруулж чадсан. 2023 ёс зүйн хороонд нийт 10 өргөдөл гомдол ирж шийдвэрлэгдсэн бөгөөд 2024 онд 6 өргөдөл гомдол ирж шийдвэрлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад ирүүлсэн гомдлын тоо 40%-аар буурсан байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
		Үйлчлүүлэгчдийн өргөдөл, гомдлын тоо 40%-иар буурсан байх	1. УНТЭ-ийн ЭМТҮЧАБА-нд 2024 онын 12 сарын 01-ний өдрийн байдлаар ЭМТҮЧАБА-д нийт 296 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирсэнээс хүсэлт -71, гомдол -199, санал 25, мэдэгдэл-1 ирж бүртгэгдсэн байна. Шийдвэрлэлтийн хувь 97.9 % 2. УНТЭ-ийн ЭМТҮЧАБА-нд 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 286 ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирсэнээс 205 (72%), санал 17 (5%), мэдэгдэл /хүсэлт/ 22 (7%), талархал 42 (16%)- ийг тус тус эзэлж байна. Шийдвэрлэлтийн хувь 96.4 % 3. 2022 онд эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албанд иргэд, үйлчлүүлэгчдээс нийт 199 өргөдөл гомдол, санал, хүсэлт ирсэн бөгөөд өргөдөл гомдлын тоо 43,7%-иар өссөн байна. Шийдвэрлэлтийн хувь 90%. Тайлант хугацаанд үйлчлүүлэгчдээс ирсэн өргөдөл гомдлын тоо нэмэгдсэн, шийдвэрлэлтийн хувь мөн нэмэгдсэн байна. Өргөдөл гомдлын тоо буураагүй тул хэрэгжилтийг тооцох боломжгүй байна.

		Үйлчилгээний соёл, ажилчдын харилцаа хандлагад өгсөн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг 30%-иар дээшлүүлэх	1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албанаас 2024 онд авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн: ➤ Хэвтэн эмчлүүлэх 15 төв, тасгийн 197 үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгаа авсанаас ерөнхий сэтгэл ханамж 89%, нийт амбулаторийн хэсгээр үйлчлүүлсэн 226 үйлчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамж 76.4% байна. 2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албанаас 2023 онд авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн: ➤ Судалгаанд Улсын Нэгдүгээр төв эмнэлгийн амбулаториор тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчид болон ГЭТ, БТ, ЦЭСЧШСТ, ЗТ, УЭСТ, ДШСДТ, МЭТ, ЕМЗТ, УАТ, ЭШСТ, ХҮСҮСТ, БШГМЗТ, ЧХХСТ, ЭНМЗТ, НЭСМЗТ, тасаг, нэгжүүдэд хэвтэн эмчлүүлж буй хэвтэн эмчлүүлэгч нар хамрагдсан. Нийт 446 үйлчлүүлэгч хамрагдсан ба 238 нь хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчид, 208 нь амбулаториор тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчид хамрагдсан байна. Амбулаториор үйлчлүүлэгчийн ерөнхий сэтгэл ханамж 83% байсан бөгөөд 2022 онтой харьцуулахад 11%-аар өссөн үзүүлэлттэй байна. Хэвтэн эмчлүүлэгчийн ерөнхий сэтгэл ханамж 89%. Үйлчлүүлэгчийн ерөнхий сэтгэл ханамжийг 2022 онтой харьцуулахад 4%-өссөн үзүүлэлттэй байна. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг жил тутамдаа 5%-иар нэмэгдүүлэхээр тооцоолсон боловч төлөвлөсөн хувьдаа хүрээгүй тул хэрэгжилтийг тооцох боломжгүй байна.
3.3	Удирдах ажилтнуудын менежментийн ур чадварыг хөгжүүлэх	Удирдлагын менежментийн чиглэлийн сургалтад нийт удирдах ажилтнууд 100% хамрагдаж, гэрчилгээгээр баталгаажигдсан байна	2021 онд: 2021 оны 10-р сард Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг, Санхүү, Эдийн Засгийн Их Сургууль хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан. УНТЭ нь 2020 оны 4-р сараас эхлэн хагас бие даасан байдалд шилжин ажиллаж эхэлсэн ба энэ оны 3-р сарын 1-ний өдрөөс ЭМДҮЗ-н 03 дугаар тоот тогтоолын дагуу эмнэлгүүд гүйцэтгэлээрээ санхүүждэг болсонтой холбоотойгоор СЭЗИС-тай эмнэлгийнхээ эдийн засаг, төлөвлөлтийн чиглэлээр хамтран ажиллах болсон. Хамтын ажиллагааны хүрээнд тус сургуулийг түшиглэн, эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллаж, бусад эмнэлгүүдэд жишиг болохуйц орлого, зарлагын өртгийг тооцоолон эмнэлгийн ашгийг зөв зохистой хуваарилан эмнэлгийн ажилчдын нийгмийн асуудал болон цалин урамшуулал дээр анхаарч ажиллах ажлуудыг хийх эхлэлийг тавсан. Уг хамтын ажиллагааны дагуу УНТЭ-ийн удирдлагууд 2021.10.19, 2021.11.02-ны өдрүүдэд байгууллагын зан төлөв, байгууллагын санхүүгийн менежмент,

		удирдлага зохион байгуулалтын 2 удаагийн бүлгийн сургалтад бүрэлдэхүүнээрээ хамрагдсан байна. Хамтын ажиллагааа 2021 онд үргэлжлээд зогссон. 2022 онд: УНТЭ-ийн ЗАА, ЗХНА-аас гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг шинэчлэх, тухайн ажилтны гүйцэтгэлтэй хэрхэн уялдуулах чиглэлээр АШУУИС-ийн НЭМХ-ийн Эрүүл мэндийн бодлого, менежментийн судалгааны төвтэй хамтран “Гүйцэтгэлийн удирдлага болон гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт” сургалтыг онол болон дадлага хэлбэрээр 2022.03.09-ны өдөр зохион байгуулж нийт 50 гаруй удирдах ажилтнууд болон ЗАА, ЗХНА-ны мэргэжилтнүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ хамрагдсан. Сургалтын сэдэв: ➤ Гүйцэтгэл, түүнд нөлөөлөх хүчин зүйлс ➤ Гүйцэтгэлийн үнэлгээ ➤ Гүйцэтгэлийг хэмжих нь ➤ Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд ➤ Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний хэлбэр, аргууд ➤ Гүйцэтгэл, түүнд нөлөөлөх хүчин зүйлс ➤ Гүйцэтгэлийг үнэлэх явцад гарах бэрхшээл, даван туулах арга зам Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022.01.12, 2022.02.25-ны өдрүүдэд АТГ-аас зохион байгуулсан 2 удаагийн онлайн сургалтад давхардсан тоогоор 90 албан тушаалтан хамрагдсан. “Эрүүл амьдралыг иргэн бүрт” ТББ-аас нийт удирдах албан тушаалтнуудад 2022.11.29, 2022.09.13-ны өдрүүдэд 2 удаа “Ажлын бүтээмж, үр дүнд суурилсан урамшуулал олгох, гүйцэтгэлийн үнэлгээний талаарх” сургалт, танилцуулгыг хийсэн. 2023 онд УНТЭ нь 2023 онд ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний компани болох “УАЙ ЭС КОНСАЛТИНГ” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажилласан. Тус ажлын хүрээнд 2023 оны 12 сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд нийт 39 алба, төв, тасаг, нэгжийн 125 удирдлага, эмч, сувилагч, мэргэжилтнүүдийг хамруулан 6 удаагийн цуврал сургалт, удирдлагуудад 2 удаагийн, дотоод аудитор бэлтгэх сургалтыг тус тус зохион байгуулсан.
--	--	--

			2024 онд Захирлын ажлын албанаас Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн “Удирдах ажилтны зөвлөгөөн” 2 удаа зохион байгуулсан. 2024 оны 2 дугаар сард Удирдлагын академийн захирал, Удирдахуйн ухааны доктор Д.Сүрэнчимэгтэй хамтран “Байгууллагын соёл, түүнийг бүрдүүлэх, хадгалах талаар” сэдэвт сургалт, 6 дугаар сард ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний компани “Уай Эс Консалтинг” ХХК-тай хамтран “Орчны шинжилгээ хийх арга зүй” талаар сургалтыг эмнэлзүйн төв тасгуудын дарга, эрхлэгч, захиргааны болон дэмжих үйлчилгээний албадын дарга, ахлах сувилагч нарт зохион байгуулсан. 2024.12.04-нд Удирдлагын академийн багш Ц.Дэлгэржаргал хамтран нийт эмнэлзүйн төв тасгуудын дарга, эрхлэгч нар, захиргааны болон дэмжих үйлчилгээний албадын дарга нарыг хамруулсан “Төрийн байгууллагын стратеги төлөвлөлт хийх арга зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Мөн удирдлагын академийн менежментийн чиглэлийн сургалтанд нийт удирдлагууд 100% хамрагдсан.
	3.4 Байгууллагын соёлыг төлөвшүүлэх манлайллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Байгууллагын соёлыг жил бүр судалгааны картаар үнэлж, хүрсэн түвшингийн нэмэгдсэн үзүүлэлт	Боловсруулж, батлуулсан, үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байгаа судалгааны карт байхгүй. Хэрэгжилтийг үнэлэх боломжгүй.
4.Олон улсын ажлын байрны жишигт нийцсэн ажилтны сургалт, хөгжлийн хөтөлбөр	4.1 Эмнэлгийн ажилтнуудын хэлний мэдлэгийн түвшинг мэргэжил тус бүрээр үнэлэх	Олон улсын батлагдсан хэлний түвшин тогтоох аргачлалаар үнэлсэн үнэлгээний дүн	УНТЭ-ийн Ерөнхий захирал Л.Бямбасүрэн, “Фаро лимитэд груп” ХХК-ийн гүйцэтгэх захирал А.Бямбажаргал нар 2024 оны 09 сарын 23-ны өдөр хамтын ажиллагааны гэрээг байгуулсан. Уг хамтын ажиллагааны хүрээнд УНТЭ-ийн ажилчид болон ажилчдын хүүхдүүдийн англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хамтарч ажиллах, мөн зохих хөнгөлөлтүүдийг олгохоор заасан бөгөөд сувилагч нарт зориулсан тусгайлан мэргэжлийн англи хэлний хөтөлбөрийг боловсруулж сургалт явуулж эхэлсэн. Хэрэгжилт 100%
	4.2 Хэлний мэдлэгийн түвшин тус бүрийг 40%-иар ахиулах	Хэлний түвшин тус бүрийн ахисан үзүүлэлт	УНТЭ-ийн Сувилахуйн алба болон Англи хэлний Фаро сургалтын төвтэй хамтран сувилагчийн ажлын байрны мэргэжлийн англи хэлний “English for Nursing” хөтөлбөрийг 2024 оны 10 сарын 1-ний өдрөөс эхлүүлсэн. Сургалт эхлүүлэхэд 60 гаруй сувилагч англи хэлний түвшин тогтоох үнэлгээнд хамрагдсан. Одоогийн байдлаар 9 сувилагч үр дүнтэй суралцаж байна. Хөтөлбөрийг Сувилахуйн алба

			болон Фаро төвийн багш нарын хамтаар сувилагчийн ажлын байранд хэрэглэгддэг түгээмэл хэрэглээний үг болон эмнэлгийн англи хэлний агуулгыг оролцуулж 12 долоо хоногийн сургалтын хөтөлбөрийг анх удаа боловсруулж хэрэгжүүлж байна. Нийт сувилагч нарын явцын дундаж үнэлгээг 3 удаа хийсэн ба хамгийн сүүлийн 11 дүгээр сарын 16-ны үнэлгээгээр 72.3% байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	4.3 Олон улсын сертификаттай сургалт, туршлага солилцох хөтөлбөрт хамрагдах эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоог 30%-иар нэмэгдүүлэх	Олон улсын баталгаажсан сертификат шинээр авсан эмнэлгийн мэргэжилтний тоо	Хүний нөөцийн чиглэлээр олон улсын баталгаажсан сертификаттай сургалтанд хамрагдсан ажилтан байхгүй. Хэрэгжилтийг үнэлэх боломжгүй.

ТЭРГҮҮЛЭХ СТРАТЕГИ 2.ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИЙГ НЭВТРҮҮЛЭН НУТАГШУУЛАХ

ЗОРИЛГО: Олон улсын эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх замаар оношилгоо, эмчилгээний шинэ технологи, инноваци, сайн туршлага, менежментийг нэвтрүүлэн нутагшуулж, Монгол улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчний тоог бууруулахад чиглэгдэнэ.

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ЗОРИЛТ	ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ	ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН, ҮНЭЛГЭЭ
1.Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний шинэ дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх /20 технологи/	1.1 Элэг шилжүүлэн суулгах технологийг өргөжүүлэн хөгжүүлэх /6 технологи/ 1. Цусны бүлэг тохироогүй донороос элэг, бөөр шилжүүлэн суулгах эмчилгээний тоог нэмэгдүүлэх /эхлүүлэх/ 2. Хүүхдэд бие даан эрхтэн шилжүүлэн суулгах 3. Насанд хүрэгчдэд элэгний зүүн дэлбэнг эдийн дэр ашиглан шилжүүлэх 4. Тархины үхэлтэй донороос элэг тайрч 2 хүнд шилжүүлэн суулгах эмчилгээг эхлүүлэх 5. Хоёр донороос элэгний 2 дэлбэнг шилжүүлэн суулгах эмчилгээ эхлээгүй.	Нэвтрүүлж, хөгжүүлсэн технологийн төрөл, эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо, үр дүн нэр тоо, тоо,	2020-2024 онд дээрх 5 технологийг 100%-ийн хэрэгжилттэй байхаар төлөвлөсөн бөгөөд дараах явцтай байна. 1. Хоёр донороос элэгний 2 дэлбэнг шилжүүлэн суулгах эмчилгээ эхлээгүй. 2. Тархины үхэлтэй донороос элэг тайрч 2 хүнд шилжүүлэн суулгах эмчилгээг эхлүүлэхэд бэлэн болсон боловч тархины үхэлтэй донорын тохиолдлын тоо цөөн байна. Нэвтрүүлсэн болон нутагшуулсан технологүүд: 1. 2023 онд элэгний зүүн дэлбэнг эдийн дэр ашиглан шилжүүлэх эмчилгээг насанд хүрэгчдэд 1 тохиолдол, хүүхдэд 1 тохиолдлыг тус тус амжилттай хийсэн. 2. Элэг шилжүүлэн суулгах мэс засалд суулгац элэгний нөхөн засалд гялтан хальс ашиглах мэс заслыг анх удаа амжилттай хийсэн. 3. Цусны бүлэг өөр донороос элэг шилжүүлэн суулгасан тохиолдол 2021 онд -2, 2023 онд -1, 2024 онд -2 нийт 5 тохиолдол амжилттай хийсэн. 4. 2024.10.17-нд Монгол улсад анх удаа 43 настай хүнд цусны бүлэг өөр донороос бөөр шилжүүлэн суулгах эмчилгээ амжилттай хийсэн. 5. УНТЭ-ийн ЭШС баг нь ЭХЭМҮТ-ийн ЭШС багтай хамтран 2022 онд 7 настай хүүхдэд амьд донороос элэг шилжүүлэн суулгах мэс заслыг -1, 2023 онд 1 настай хүүхдэд элэг шилжүүлэн суулгах, 2024 онд 12 настай хүүхдэд элэг шилжүүлэн суулгах эмчилгээг тус тус амжилттай хийсэн. 2024 оны жилийн эцсийн байдлаар тус хэсгийн хэрэгжилт 80%-тай байна.

	1.2 Бөөр шилжүүлэн суулгах технологийг өргөжүүлэн хөгжүүлэх /4 технологи/ 1. Тархины үхэлтэй донороос эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах технологийг хөгжүүлэх, өргөжүүлэх /элэг, бөөр, нойр булчирхай/ 2. Цусны бүлэг тохироогүй донороос элэг, бөөр шилжүүлэн суулгах эмчилгээний тоог нэмэгдүүлэх /эхлүүлэх/ 3. Бөөр, нойр булчирхайг зэрэг шилжүүлэн суулгах эмчилгээг эхлүүлэх 4. Хүүхдэд бие даан эрхтэн шилжүүлэн суулгах	Нэвтрүүлж, хөгжүүлсэн технологийн төрөл, эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн үр дүн нэр тоо, тоо,	2020-2024 онд дээрх технологиуд нь 100%-ийн хэрэгжилттэй байхаар төлөвлөсөн бөгөөд дараах явцтай байна. 1. 2020 онд тархины үхэлтэй донороос 3 удаа, 2021 онд 3 удаа, 2022 онд 1 удаа, 2023 онд 1 удаа, 2024 онд 3 удаа нийт 11 удаа элэг шилжүүлэн суулгах эмчилгээ хийсэн. 2020 онд тархины үхэлтэй донороос 6 удаа, 2021 онд 8 удаа, 2022 онд 4 удаа, 2023 онд 4 удаа, 2024 онд 5 удаа нийт 16 тохиолдлоос 32 бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг амжилттай хийсэн. 2. Цусны бүлэг өөр донороос 2 тохиолдолд 2021.04.08, 2021.09.15-д элэг шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг амжилттай хийсэн. 2023.05.14 нд УНТЭ-т Монгол улсад анх удаа 16-тай хүүхдэд цусны бүлэг өөр донороос бөөр шилжүүлэн суулгах эмчилгээг хийсэн. 2023.11.03-нд Цусны бүлэг өөр донороос элэг шилжүүлэн суулгах мэс заслын дахин 1 тохиолдол хийсэн. 2024.10.17-нд УНТЭ-т Монгол улсад анх удаа 43 настай хүнд цусны бүлэг өөр донороос бөөр шилжүүлэн суулгах эмчилгээ амжилттай хийсэн. 3. 2022.06.19-д ЭХЭМҮТ-д элэг шилжүүлэн суулгах мэс заслыг нутагшуулах зорилгоор УНТЭ-ийн ЭШС баг нь ЭХЭМҮТ-ийн ЭШС багтай хамтран 7 настай хүүхдэд амьд донороос элэг шилжүүлэн суулгах мэс заслыг амжилттай хийсэн. 2022.09.22-д БНСУ-ын Сөүлийн их сургуулийн эмнэлэг, УНТЭ-ийн хамтын ажиллагааны хүрээнд БШС баг нь 9 настай БЖИ 13кг/м2 доош жинтэй хүүхдэд амьд донороос бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг Монгол улсад анх удаа УНТЭ-т амжилттай хийлээ. 2023 оны 6 сард УНТЭ, ЭХЭМҮТ, Япон улсын Хүүхдийн эрүүл мэнд хөгжлийн үндэсний төвийн элэг шилжүүлэн суулгах багийн хамт олонтой 1 настай хүүхдэд амьд донороос элэг шилжүүлэн суулгах мэс засал, 2024 оны 3 сард УНТЭ, ЭХЭМҮТ-ийн элэг шилжүүлэн суулгах багийн хамт олонтой 12 настай хүүхдэд амьд донороос элэг шилжүүлэн суулгах мэс заслыг тус тус амжилттай хийсэн. 4. Бөөр, нойр булчирхайг зэрэг шилжүүлэн суулгах эмчилгээг эхлүүлээгүй, багийн гишүүд сургалтанд хамрагдаж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар тус хэсгийн хэрэгжилт 90%-тай байна.
--	---	--	--

	1.3 Нойр булчирхай шилжүүлэн суулгах шинэ технологийг нэвтрүүлэн нутагшуулах /2 технологи/ 1. Нойр булчирхай шилжүүлэн суулгах технологийг нэвтрүүлж нутагшуулах 2. Бөөр, нойр булчирхайг зэрэг шилжүүлэн суулгах эмчилгээг эхлүүлэх	Нэвтрүүлж, хөгжүүлсэн технологийн төрөл, эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн үр дүн нэр тоо, тоо,	Тус технологиудыг 2024 оны жилийн эцсийн байдлаар нэвтрүүлж, нутагшуулж эхлээгүй бөгөөд зохион байгуулалтын хувьд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. 1. УНТЭ-ийн ерөнхий мэс заслын тасаг, дотоод шүүрэл судлал, диабетийн төв, эрхтэн шилжүүлэн суулгах төв болон бусад төв тасгийн эмчийн баг хамтран “Нойр булчирхай шилжүүлэн суулгах эмчилгээний заавар” боловсруулж, ЭМС-ын 2020 оны “Заавар батлах тухай” А/353 тоот тушаалаар батлуулсан. Мөн БНСУ-ын Асан эмнэлгийн эмчилгээ, сувилахуйн зааврыг орчуулсан. 2. ЕМЗТ-ийн эмч С.Эрдэнэ, С.Отгонбаяр нар тархины үхэлтэй донороос нойр булчирхайг авах, угаах, ширээн дээрх мэс засал 4 тохиолдолд хийсэн. 3. 2023.03.01- 10.30 хүртэлх хугацаанд Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн их эмч Г.Баярбилэг, Б.Бат-Ирээдүй, сувилагч Ө.Мягмарсүрэн нар элэг, нойр булчирхай шилжүүлэн суулгах чиглэлээр Асан эрүүл мэндийн төвд дадлагажих, мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан. 4. 2023.05.02-05.31 хүртэлх хугацаанд Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн их эмч С.Отгонбаяр, Б. Баярмагнай нар нойр булчирхай шилжүүлэн суулгах чиглэлээр Асан эрүүл мэндийн төвд дадлагажих, мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан. Суралцах хугацаанд тасгийн эрхлэгч Ким болон Шин профессор нарыг дагалдан суралцаж нойр булчирхайн мэс засал 1, кадавер донорын мэс засал 1, бөөр шилжүүлэн суулгах 10 мэс засал (рецепиент, донор) тус тус ажигласан. 5. 2024 онд Дотоод шүүрэл судлал, диабетийн төвийн их эмч С.Булган нойр булчирхай шилжүүлэн суулгах чиглэлээр сургалтанд хамрагдсан. 2024 оны жилийн эцсийн байдлаар тус хэсгийн хэрэгжилт 60%-тай байна.
	1.4 Үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээг нэвтрүүлэх, өргөжүүлэн хөгжүүлэх, хүйн цусны банк байгуулах /4 технологи/ 1. Алло-трансплантац буюу донороос үүдэл эс шилжүүлэн суулгах	Нэвтрүүлж, хөгжүүлсэн технологийн төрөл, эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн үр дүн нэр тоо, тоо,	2024 оны жилийн эцсийн байдлаар тус 4 технологи 100%-ийн хэрэгжилттэй, 2 технологи 50%-ийн хэрэгжилттэй, бусад технологийн хувьд хэрэгжилтийг тооцох боломжгүй тул хэсгийн дундаж 70%-тай байна. 1. УНТЭ-ийн Цусны эмгэг судлал, чөмөг шилжүүлэн суулгах төв нь 2022 оны III-р улиралд МУ-д анх удаа цусны хорт хавдрын эмчилгээний үед донороос үүдэл эс суулгах буюу “Алло-үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээ”-г 1

	2. Хүйн цусны банк байгуулах 3. Бусад эмгэгийн үед үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээг нэвтрүүлэх, нутагшуулах 4. Мэдрэлийн зарим эмгэгийн үед үүдэл эс шилжүүлэн суулгах технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх		үйлчлүүлэгчдэд амжилттай хийсэн. Тус эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэхийн тулд ЭМЯ-наас 1,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээний өмнөх ба дараах эмчилгээнүүдийг хийх хими эмчилгээний хэсгийг шинээр тохижуулсан. Цусны үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээний хэсэг болох “Класс -100” өрөөг засварласан. Мөн ЭЭСНЛ-т өндөр нарийвчлалтай эдийн тохироо үзэх лабораторийн аппаратыг суурилуулсан. 2024 оны 08 сарын 11-нд 23 настай эрэгтэйд 100% эдийн тохироо тохирсон төрсөн дүүгээс нь алло-үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээг БНЭУ-т тухайн улсын Маринго-Ази эмнэлгийн эмч нартай хамтран хийсэн бөгөөд өвчтөний хяналт одоо Монгол Улсад үргэлжилж байна. 2. Хүйн цусны банк байгуулах чиглэлээр ➤ ЭМС-ын 2020 оны А/236 тоот “Журам батлах тухай” тушаалаар үүдэл эс болон хүйн цусны банк байгуулах, ажиллах журмыг баталсан. ➤ 2020 онд Нийслэлийн өргөө амаржих газар 1 эх барих эмэгтэйчүүдийн эмч, 4 эх баригч, 1 нярайн эмч, 2 нярайн сувилагчид хүйн цусны банк, хүйн цусыг хэрхэн цуглуулах талаар сургалт орсон. ➤ Хүйн цусны банк байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн захиалга хийснээс safety cabine болон центрфуг нийлүүлэгдсэн. Бусад зүйлс одоогоор нийлүүлэгдэх боломжгүй, байгуулах газар, санхүүжилтийн байдал тодохойгүй байна. 3. Бусад эмгэгийн үед үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээг нэвтрүүлэх нутагшуулах чиглэлээр 2019-2020 онд Хэрх үе судлал, үений мэс заслын тасаг нь ЦЭСЧШСТ-тэй хамтран өвдөгний үений мөгөөрсийн гэмтлийг үүдэл эсээр эмчлэх эмчилгээг 1 үйлчлүүлэгчид амжилттай хийсэн. 4. Мэдрэлийн зарим эмгэгийн үед үүдэл эс шилжүүлэн суулгах технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх байгуулах тус ажлын хэрэгжилтийг тооцох боломжгүй. 2024 оны жилийн эцсийн байдлаар тус хэсгийн хэрэгжилт 70%-тай байна.
--	--	--	---

	1.5 Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний чиглэлээр лабораторийн молекул генетикийн технологиудыг нэвтрүүлэх, нутагшуулах 1. Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний чиглэлээр молекул генетикийн технологиудыг нэвтрүүлэх, нутагшуулах	Нэвтрүүлж, хөгжүүлсэн лабораторийн технологийн нэр төрөл, тоо, үр дүн	Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний чиглэлээр молекул генетикийн технологиудыг нэвтрүүлэх, нутагшуулах 1. Тус шинжилгээг ЭЭСНЛ-т хийгддэг болсоноор цусны хорт хавдрыг илрүүлэх шинжилгээнд дэвшил гарах, иргэд даатгалаараа тус шинжилгээнд хамрагдах зэрэг олон давуу талтай бөгөөд 2021 онд ЭЭСНЛ-т цусны хорт хавдрын оношлогоонд 28 хромосомын транслокацийг илрүүлэх шинжилгээг амжилттай нэвтрүүлж, үүнээс Филадельфийн хромосом t(9;22) 27(60%) илэрч оношийг молекул генетикийн түвшинд тавьснаар байд чиглэсэн молекул эмчилгээг хийх боломжтой болж, нийт 45 хүнд хийсэн бөгөөд үр дүнгийн судалгаа хийгдсэн. Тус шинжилгээг хийснээр цус төлжүүлэх болон лимфойд эдийн хавдрын үед хавдрын эсүүдэд илрэх хромосомын гажиг, генийн өөрчлөлтүүд, эсийн гадаргууд илрэх иммунофенотипийн онцлогийг тодорхойлох нь оношийг нарийвчлан тавих, ДЭМБ-н ангиллаар хавдрыг ангилах, тавиланг урьдчилан таамаглах, эмчилгээг зөв төлөвлөх болон эмчилгээний дараа өвчнийг хянах зэрэг маш өндөр ач холбогдолтой. 2. 2022 онд BCR/ABL major болон minor ген тоолох шинжилгээний стандарт ажиллагааны зааврыг боловсруулж тус шинжилгээг эмнэлзүйд бүрэн нэвтрүүлсэн. Мөн жинхэнэ нөхцөлдүүлэгч JAK2 V617F генийн мутацийг илрүүлэх шинжилгээний стандарт ажиллагааны зааварчилгааг боловсруулж, нийт 30 хүнд шинжилгээг хийсэн. JAK2 V617F мутацийг PV-тэй 13 өвчтөнд үзэхэд 92.3% (12/13) хувьд илэрсэн. Эдгээр шинжилгээ нь цусны хорт хавдрын оношилгоонд, үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээний тактикт зайлшгүй шаардлагатай оношилгоо юм. 2023 онд: 1. Flow cross match шинжилгээг бүрэн нэвтрүүлсэн 2. CMV вирус тоолох шинжилгээг бүрэн нэвтрүүлсэн 3. EBV вирус тоолох шинжилгээг бүрэн нэвтрүүлсэн 4. BK вирус тоолох шинжилгээг бүрэн нэвтрүүлсэн 5. Инсулин тодорхойлох шинжилгээг бүрэн нэвтрүүлсэн 6. С пептид тодорхойлох шинжилгээг бүрэн нэвтрүүлсэн 7. Protein S шинжилгээг бүрэн нэвтрүүлсэн 8. Protein C шинжилгээг бүрэн нэвтрүүлсэн
--	--	--	---

			9. IL-6 тодорхойлох шинжилгээг бүрэн нэвтрүүлсэн 10. NGAL тодорхойлох шинжилгээг бүрэн нэвтрүүлсэн 2024 оны жилийн эцсийн байдлаар тус хэсгийн хэрэгжилт 100%-тай байна.
	1.6 Хиймэл үе солих мэс заслын технологийг нэвтрүүлэх, өргөжүүлэн хөгжүүлэх /3 технологи/ 1. Донорын шөрмөс, ясны банк байгуулах 2. Мөрний хиймэл үе солих мэс заслыг эхлүүлэх, нутагшуулах 3. Ясны том хэмжээний дутмагшил, үе дайрсан ясны хортой, хоргүй хавдрын үеийн мэс засал болон хими эмчилгээний технологийг нэвтрүүлэх, хими эмчилгээний эмч бэлтгэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Нэвтрүүлж, хөгжүүлсэн технологийн төрөл, эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн үр дүн нэр тоо, тоо,	1. Кадавер яс болон шөрмөс шилжүүлэн суулгах заавар боловсруулагдаж, банк байгуулах ажлыг 2022 онд эрчимжүүлэн Эмнэлзүй эмгэг судлалын нэгдсэн лабораторийн тасагт гүн хөлдөөгчийг байрлуулан кадавер яс, шөрмөсийг хадгалж, мэс засал хийж байна. 2. 2021 онд ХҮСҮСТ нь хандиваар дурангын иж бүрдэл аппараттай болсон бөгөөд МУ-д нэвтрүүлж, нутагшаагүй байсан мөрний үе солих мэс заслыг 2 үйлчлүүлэгчид амжилттай хийж бүрэн нутагшуулсан. Мөн дурангаар мөрний эмгэгийн мэс заслуудыг хийж эхэлсэн. 3. 2023 онд Монгол улсад анх удаа атгаал ясны дээд 2/3-г хамарсан том хэмжээний ясны хортой (osteosarcoma) хавдрын тохиолдолд хавдрыг бүхэлд нь аван мега-протез суулгах мэс заслыг амжилттай хийж гүйцэтгэсэн. 2024 оны жилийн эцсийн байдлаар тус хэсгийн хэрэгжилт 100%-тай байна.
2. Эмчилгээ, оношилгооны дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэн нутагшуулах /72 технологи/	2.1 Бага хүрцийн буюу дурангийн мэс заслын технологийг өргөжүүлэн хөгжүүлэх /11 технологи/ 1. Үе сэргээх төвд үений дурангийн мэс заслыг хөгжүүлэх, мөрний дурангийн мэс заслыг бүрэн нутагшуулах 2. Хамар судлалын чиглэлээр Endoscopic skull base surgery буюу гэмтлийн болон бусад шалтгаант духны ясны цөмрөл, тархины дух хэсгийн буглаат үрэвслийг дурангийн мэс заслын аргаар эмчлэх технологи, суурийн хөндийн хавдар, өнчин тархины хавдрыг дурангийн аргаар авах мэс	Нэвтрүүлж, хөгжүүлсэн технологийн төрөл, эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн үр дүн нэр тоо, тоо,	Тус ажлын хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн. 1. 2021 онд ХҮСҮСТ нь хандиваар дурангын иж бүрдэл аппараттай болсон бөгөөд МУ-д нэвтрүүлж, нутагшаагүй байсан мөрний үе солих мэс заслыг амжилттай хийж бүрэн нутагшуулсан. Мөн дурангаар мөрний эмгэгийн мэс заслуудыг хийж эхэлсэн. 2. Чих хамар хоолой, мэс заслын тасгийн хагалгааны хэсэгт ЭМЯ-ны санхүүжилтээр ENT navigation system дурангийн хамт суурилагдсан бөгөөд тус Brainlab navigation system нь тархи, мэдрэл, чих хамар хоолойн мэс ажилбарын үед хяналт хийх, эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх зориулалттай хяналтын төхөөрөмж юм. УНТЭ-ийн ЧХХМЗТ нь ENT navigation system-ийг ашиглан хүндрэлтэй болон гавлын суурийн мэс заслуудыг хийж эхлэх боломж бүрдсэн бөгөөд хамрын дурангийн хүрцээр өнчин тархины хавдар авах мэс

	заслын технологийг нэвтрүүлэх, нутагшуулах 3. Ерөнхий мэс заслын чиглэлээр дурангаар цээжний хөндийн хагалгаа, элэг тайрах, нойр булчирхай, ивэрхий, ходоод, нарийн гэдэс, бамбай болон бөөрний дээд булчирхайн мэс заслуудыг хийж бүрэн нутагшуулах 4. Дурангийн симпатэктоми (хөлийн шархны хүндрэл, хөл тайрахаас урьдчилан урьдчилан сэргийлэх) мэс заслыг нэвтрүүлэх, хөгжүүлэх 5. Шулуун гэдэсний урвалт болон дотор гэдэс унжих өвчний үед дурангийн мэс засал хийх технологийг нэвтрүүлэх 6. Transanal microsurgery буюу хошногон дотуурх дурангийн бичил мэс заслын технологийг нэвтрүүлэх, нутагшуулах		заслыг 1 өвчтөнд УНТЭ-д анх удаа АНУ-ын Virtue Foundation-ы эмч нартай хамтран амжилттай хийсэн. 3. ЕМЗТ-т 2023 оны байдлаар дурангийн мэс заслын чиглэлээр дараах технологүүд нэвтрээд байна. ➢ Дурангаар дэлүү авах мэс засал ➢ Дурангаар 12 хуруу гэдсийг нарийн гэдэстэй залгах ➢ Дурангаар бөөрний дээд булчирхай авах мэс засал ➢ Дурангаар болон нээлттэй элэг тайрах мэс засалд ICG /indocyanin green/ хэрэглэх 2024 онд хэвлийн дурангий аргаар Wipple мэс засал, бамбай булчирхай дурангаар авах /бамбайн дуран голын хүрцээр/ мэс засал, Single insional-intra gastric resection мэс засал, Thoracoscopic pleural decortication мэс засал зэрэг дурангийн мэс заслуудыг 4. Дурангийн симпатэктоми (хөлийн шархны хүндрэл, хөл тайрахаас урьдчилан урьдчилан сэргийлэх) мэс заслыг нэвтрүүлэх, хөгжүүлэх 5. БШГМЗТ нь хэвлийн дурангийн бүдүүн гэдэсний баруун тал тайрахад хэвлийн дотор залгалт хийх технологийг нэвтрүүлсэн. Бүрэн нутагшсан 4 тохиолдол хийгдсэн. 6. 2023 онд дахисан шулуун гэдэсний өмөнгийн мэс засал Total exentration /anterior ба posterior / болон умайн болон шулуун гэдэсний урвалтыг дурангийн аргаар засах дурангийн технологийг нэвтрүүлсэн. 2024 онд байгалийн нүхээр мэс заслын сорьцыг гаргах болон хэвлийн дотор залгалт хийх технологи (TAMIS ажилбар)-ын 5 тохиолдлыг БШГМЗТ-ийн эрхлэгч, их эмч Э.Бат-Өлзий нь багийн хамт 5 тохиолдол амжилттай хийсэн. Тус мэс заслын технологи нь хоргүй өмөн гэмтэл болон эрт үеийн өмөнтэй сонгогдсон өвчтөнүүдэд мэс заслын дараах өвчлөл багатай, бага зэргийн гэмтэлтэй мэс засал юм. Мөн энэ ажилбарыг хийж нутагшуулсанаараа хошногон дотуурх дурангийн бичил мэс засал (TEM) Хошногон дотуурх дурангийн мэс засал (ТЕО) Transanal Total Mesorectal Excision (taTME) зэрэг шулуун гэдэсний доод хавдартай өвчтөнүүдэд зориулсан
--	---	--	--

	7. Эрүү нүүрний мэс заслын технологт үений дурангийн мэс заслыг нэвтрүүлэх		уламжлалт мэс заслыг бага гэмтэлтэй шинэ хувилбараар хийх суурь болсон. 7. Эрүү нүүрний мэс заслын технологт үений дурангийн мэс засал хийгдэж эхлээгүй. 2020-2024 онд хэрэгжилтийг 100%-тай байхаар тооцсон. 2024 оны жилийн эцсийн байдлаар тус хэсгийн хэрэгжилт 70%-тай байна.
	2.2 Дүрс оношилгооны дэвшилтэт 13 технологийг нэвтрүүлэх, өргөжүүлэн хөгжүүлэх /дуран-4 технологи, цөмийн онош зүй-4 технологи, КТГ, MRI, PET CT-5 технологи/ 1. Microwave ablation эмчилгээг элэгний болон бусад цуллаг эрхтэний хавдрын эмчилгээнд нэвтрүүлэх 2. Тэсла 1.5 CPT суурилуулж, элэгний сонгомол тодосгогчтой шинжилгээ, түрүү булчирхай, мөчдийн нэмэлт шинжилгээг хийх 3. BRTO, TIPS эмчилгээ буюу элэгний хатууралтай өвчтөний цус алдах эрсдлийг бууруулах эмчилгээний технологи нэвтрүүлэх 4. Зүрхний титэм судасны КТГ, зүрхний соронзон резонанс томографи буюу MRI болон бүдүүн шулуун гэдэсний КТГ-т колоноскопи зэрэг шинэ оношилгооны аргуудыг нэвтрүүлэх.	Нэвтрүүлж, хөгжүүлсэн технологийн нэр тоо, оношилгоонд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо, үр дүн	Тус ажлын хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн: 1. Microwave ablation эмчилгээг эмнэлзүйд бүрэн нэвтрүүлсэн. 2. Тэсла 1.5 CPT суурилуулж, элэгний сонгомол тодосгогчтой шинжилгээ, түрүү булчирхай, мөчдийн нэмэлт шинжилгээг бүрэн хийх боломжтой болсон. 3. BRTO, TIPS эмчилгээг эхлүүлэх ажлын хувьд эмч мэргэжилтнүүд бэлтгэгдсэн. Эмнэлзүйн тохиолдол гарсан үед эмчилгээг нэвтрүүлэхэд бэлэн болсон. 4. Зүрхний титэм судасны КТГ хийх хүний нөөц бэлтгэгдсэн, програм худалдан авалт хийгдсэн тохиолдолд оношилгоог хийх боломжтой, зүрхний соронзон резонанс томографи буюу MRI нь одоо ашиглаж буй хуучин MRI аппаратад дээр болохгүй бөгөөд 2024 онд ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар

	5. Түрүү булчирхайн хорт хавдрын цөмийн эмчилгээг нэвтрүүлэх 6. Үений үрэвслийн эсрэг изотоп эмчилгээг нэвтрүүлэх 7. Мөчдийн өнгөц венийн судсыг түлэх Microwave ablation болон умайн миома бөглөх эмчилгээг нэвтрүүлэх 8. Перфузын КТГ оношилгоог мэдрэл, хавдрын эмчилгээний дараах хяналт хийхэд нэвтрүүлэх 9. Цөмийн онош зүйн чиглэлээр үрэвсэлт эмгэгийн цөмийн оношилгоо болон нейроэндокринный хавдрын оношилгоог нэвтрүүлэх 10. Цөмийн онош зүйн чиглэлээр PET/CT суурилуулж, хорт хавдар, зүрх судас, тархины бодисын солилцооны ПЭТ/СТ оношилгоог нэвтрүүлэх (Молекул биологийн оношилгоог нэвтрүүлэх) 11. PARTO эмчилгээ буюу элэгний хатууралтай өвчтөний цус алдах эрсдлийг бууруулах эмчилгээний технологи нэвтрүүлэх		нийлүүлэгдэх шинэ MRI аппаратанд програм нь суурилагдсан тул хийгдэх боломжтой, бүдүүн шулуун гэдэсний КТГ-т колоноскопи зэрэг шинэ оношилгооны аргуудыг нэвтрүүлэх чиглэлээр 3 тохиолдол хийсэн, цаашид нэвтрүүлэх бүрэн боломжтой. 5. Түрүү булчирхайн хорт хавдрын цөмийн эмчилгээг нэвтрүүлээгүй. 6. Үений үрэвслийн эсрэг изотоп эмчилгээг нэвтрүүлээгүй. 7. Мөчдийн өнгөц венийн судсыг түлэх Microwave ablation болон умайн миома бөглөх эмчилгээг нэвтрүүлж эхэлсэн. 8. Перфузын КТГ оношилгоог мэдрэл, хавдрын эмчилгээний дараах хяналт хийхэд нэвтрүүлэх хүний нөөц, эмч бэлтгэгдсэн бөгөөд програм худалдан авалт хийгдэхийг хүлээж байна. 9. Цөмийн онош зүйн чиглэлээр үрэвсэлт эмгэгийн цөмийн оношилгоо болон нейроэндокринный хавдрын оношилгоог нэвтрүүлэх оношилгоо хийгдэж эхлээгүй. 10. Цөмийн онош зүйн чиглэлээр PET/CT суурилуулж, хорт хавдар, зүрх судас, тархины бодисын солилцооны ПЭТ/СТ оношилгоог нэвтрүүлэх үйл ажиллагаа хэрэгжээгүй. 11. PARTO эмчилгээ буюу элэгний хатууралтай өвчтөний цус алдах эрсдлийг бууруулах эмчилгээний технологи нэвтрүүлээгүй. 12. Үйл ажиллагааны болон перфузын MRI шинжилгээг хавдарын эрт үеийн оношилгоо, тархины эмгэгийн оношилгоонд нэвтрүүлэх үйл ажиллагаа хэрэгжээгүй.
--	---	--	---

	12. Үйл ажиллагааны болон перфузын MRI шинжилгээг хавдарын эрт үеийн оношилгоо, тархины эмгэгийн оношилгоонд нэвтрүүлэх /application авах/ 13. Ангиографийн чиглэлээр ясны болон хөхний хавдрын хөлдөөх буюу cryoablation технологийг нэвтрүүлэх		13. Ангиографийн чиглэлээр ясны болон хөхний хавдрын хөлдөөх буюу cryoablation технологийг нэвтрүүлээгүй. 2020-2024 онд хэрэгжилтийг 100%-тай байхаар тооцсон бөгөөд нийт 13 технологос 4 технологийг нэвтрүүлсэн, хүний нөөц бэлтгэгдсэн бөгөөд хэрэгжилт хангалтгүй 9 ажил байгаа тул хэрэгжилтийн дундаж 30%-тай байна.
	2.3 Гаж хөгжлийн болон нөхөн сэргээх мэс заслыг хөгжүүлэх /5 технологи/ 1. Эрүү нүүрний мэс заслын чиглэлээр шилбэний ясыг судас булчингийн хамт авч эрүүний өмнө ясны гажгийг нөхөн сэргээх мэс заслыг нэвтрүүлэх, нутагшуулах 2. Эрүү, үе нөхөн сэргээх ортогнатик мэс заслын технологийг бүрэн нутагшуулах 3. Шүдний имплант эмчилгээг нэвтрүүлэх	Нэвтрүүлж, хөгжүүлсэн технологийн нэр тоо, төрөл, эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо, үр дүн	Тус ажлын хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн: 1. УНТЭ-ийн Эрүү нүүрний мэс заслын тасагт нөхөн сэргээх хагалгааг нутагшуулах, үйл алдагдах гоо зүйг сэргээх зорилго тавин ажилласан бөгөөд alloplastic болон auto bone graft хагалгааг дараах тохиолдлуудад амжилттай хийж бүрэн нутагшуулаад байна. ➤ Хоншоорын хавдарыг авсаны дараах өмнөд хана сэргээсэн тохиолдол, ➤ Төрөлхийн уруул тагнайн сэтэрхий, түүшэн ясны дефектийг ташааны дэлбэн, эрүүний ооч хэсгийн ясаар нөхөн сэргээх хагалгаа. Ташааны дэлбэн-1, Оочны яс-1, ➤ Эрүүний үений хавдарыг тайрч үйлийг буюу /зуултыг засах/ сэргээсэн тохиолдол -2 ➤ Linear scleroderma forehead өвчтөнд хэвлийгээс өөх авч шилжүүлэн гажигийг зассан тохиолдол-1 ➤ Төрөлхийн уруул-тагнайн сэтэрхийн үед хоншоорын ясыг оочоос яс аван нөхөн сэргээх мэс засал-2 ➤ АВБЕ буюу дээд уруулын согогийг доод уруулаас тэжээгч судасны хамт далбан эргүүлэх мэс засал-2 ➤ Төрөлхийн тагнайн сэтэрхий нөхөх мэс заслын дараах зөөлөн тагнайн дутагдлыг Залгиурын арын далбан /Posterior Pharyngeal Flap/-р нөхөн сэргээх мэс засал -1 ➤ Галт зэвсгийн улмаас үүссэн тагнайн согогийг Хэл болон хацрын өөхөн эдийн далбан /Tongue and buccal fat flap/-р нөхөн сэргээх мэс засал-1 2. Эрүү, үе нөхөн сэргээх ортогнатик мэс заслын технологийг бүрэн нутагшуулах чиглэлээр эрүүний /ортогнатик/ мэс засал буюу шаамий засах мэс засал -5

			3.2023 оны жилийн эцсийн байдлаар шүдний имплант эмчилгээг нэвтрүүлж эхлээгүй байна. 2020-2024 онд хэрэгжилтийг 100%-тай байхаар тооцсон. 2024 оны жилийн эцсийн байдлаар тус хэсгийн хэрэгжилтийг нийт 3 технологигоос 2 технологи бүрэн нэвтэрсэн тул 80 %-тай хэмээн дүгнэлээ.
2.4 Зүрх судас, уушги, харшил, мэдрэлийн эмгэгийн үеийн оношилгоо, эмчилгээний болон мэс заслын технологийг нэвтрүүлэх, өргөжүүлэн хөгжүүлэх /20 технологи/ 1. Уушгины эмгэгийн үеийн оношилгоог сайжруулах зорилгоор гуурсан хоолойд эхо хяналттай дурангаар эдийн шинжилгээ авах (EBUS) технологийг нэвтрүүлэх 2. Титмийн артерийн нарийслын үеийн цусны урсгалын зөрүү үнэлэгч (FFR fractional flow reserve) шинжилгээний аргыг нэвтрүүлэх 3. Зүрхний хэм алдагдлын абляци эмчилгээг нэвтрүүлэх 4. Өгсөх уруудах гол судсан судсан дотуурх мэс заслын аргаар графт стент суулгах 5. Гол судасны хавхлагын нарийслыг судсан дотуурх мэс заслын аргаар эмчлэх	Нэвтрүүлж, хөгжүүлсэн технологийн төрөл, эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн үр дүн нэр тоо, тоо,	Тус ажлын хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн: 1. Гуурсан хоолойд эхо хяналттай дурангаар эдийн шинжилгээ авах (EBUS) технологийг бүрэн нэвтрүүлсэн. 2023 онд УХСТ-ийн эмчийн тус оношилоог нийт 18, 2024 онд 16 нийт 34 үйлчлүүлэгчдэд хийсэн. 2. Phillips фирмийн /Volcano Eagle Eye Platinum Digital IVUS catheter/ судасны хэт авиан үүсгэн бүртгэгчээр нарийслын бүтэц, уртыг тодорхойлж, Volcano FFR даралт хэмжигч чиглүүлэгчээр нарийслын өмнөх, дараах даралтыг зөрүүг үнэлж, стент суулгасны дараа дахин хэт авиан хяналтаар үнэлдэг оношилгооны аргыг нэвтрүүлж баг хамт олноороо тасралтгүй үргэлжлүүлэн хийж байна. Тус технологийг зүрхний төвийн эмчийн баг нь бүрэн нэвтрүүлсэн. 3. УНТЭ-ийн Зүрхний төвийн хэм алдагдлын баг нь гадаад хамтын ажиллагааны гэрээтэй эмнэлгүүдтэй хамтран зүрхний хэм алдагдлын эмчилгээг хийж эхлээд байна. 2022 онд 10 тохиолдол, 2023 онд 36, 2024 онд 80 нийт 126 тохиолдлыг гадаад эмч нартай хамтран хийгээд байна. 4. Өгсөх уруудах гол судсан судсан дотуурх мэс заслын аргаар графт стент суулгах технологийг нэвтрүүлээгүй. 5. Гол судасны хавхлагын нарийслыг судсан дотуурх мэс заслын аргаар эмчлэх технологи нэвтрүүлээгүй.	

	6. Мэдрэлийн эмгэгийн болон харвалтын тусламж үйлчилгээг хөгжүүлэх, мэдрэл-булчингийн бичлэг, тархины судасны оношлогоо, нойр судлалын технологиудыг нэвтрүүлэх		Тархины судсан дотуурх мэс заслыг хөгжүүлэх чиглэлээр дараах мэс заслын технологиудыг амжилттай нэвтрүүлсэн. 1. Тархины судасны цүлхэнг стент/ SAC / болон баллоны /BAC/ тусламжтай бичил ороомогоор битүүлэх мэс заслын дараахь байдал 2. Гүрээний дотор артерийн нарийсалд стент тавих мэс засал 3. Тархины судасны цүлхэнд урсгал өөрчлөгч стент тавих хагалгаа 4. Артери-Венийн мальформаци 5. Нугалам болон суурийн артерийн нарийсалд стент тавих мэс засал 6. Хамрын болон тархины суурийн хөндийн хавдарыг тэжээгч судсыг дотроос битүүлэх мэс засал 7. Хамрын эмгэг судасжилтыг судсан дотроос бөглөх мэс засал 8. Нугасны артери-венийн мальформаци 9. Судасны агчил тавиулах эмчилгээ, Спазмолитик эмчилгээ 10. Тархины судасны цүлхэнд урсгал өөрчлөгч стент байрлуулах мэс засал 11. Тархины судасны цүлхэнг стентний тусламжтай бичил ороомогоор битүүлэх мэс засал 12. Тархины судасны цүлхэнг баллоны тусламжтай бичил ороомогоор битүүлэх мэс засал 13. Тархины судасны артери-венийн судасны эмгэг сүлжээрлийг судсан дотроос битүүлэх мэс засал 14. Тархины судасны нарийсалд стент тавих мэс засал 15. Тархины цус тасалдах харвалтын үед судсан дотроос тромбозектомия хийх мэс засал 16. Гавал ба нугасны суваг доторх буглаа ба гранулом 17. Хордлогот энцефалит, тархи нугасны бусад эмгэг 18. Тархины цус харвалт, шигдээс, тархины судасны эмгэгүүд 19. Тархины хоргүй хавдар 20. Тархины судасны цүлхэн 21. Гавлын гаднах болон доторх судасны нарийсал, бөглөрөл 22. Гурвалсан болон нүүрний мэдрэлийн эмгэг 23. Олдмол болон төрөлх тархи усжих
--	--	--	---

	7. Тархины судсан дотуурх мэс заслыг хөгжүүлэх 8. Мэдрэлийн ангиографи оношилгоо, тархины судасны цүлхэнг бөглөх эмчилгээг нэвтрүүлэх	24. Мэдрэлийн тогтолцооны бусад төрөлх гажиг 25. Мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэг 26. Дээд мөчдийн мононевропати 27. Тархины бусад эмгэг 28. Яс ба үений мөгөөрсний хоргүй хавдар 29. Нурууны остеохондроз, дорсопати 30. Спондилопати 31. Дорсалги 32. Нугалам, зээрэнцгийн эмгэг, гулсалт 33. Хорт хавдрын бусад мэс засал Тархины судсан дотуурх мэс заслыг хөгжүүлэх чиглэлээр дараах мэс заслын технологудыг амжилттай нэвтрүүллээ. 1. Гүрээний дотор артерийн нарийсалд хийх эндартерэктоми 2. Тархины шигдээст хийх гавлын гадна-дотор байпасс (2 донор, 2 реципиент судастай) 3. Сэрүүн нөхцөлд тархины дахьсан хавдар авах 4. Гүн хөлдөөсөн аутографтаар гавлын цоорхой нөхөх 5. Пресигмойд хүрцээр бага тархи-нүүрний булангийн хавдар авах 6. Транспедикуляр хүрцээр корпэктоми хийх Нейроангиографийн мэс заслын чиглэлээр 1. Тархины судасны катетерт ангиографи 2. Тархины судасны хагараагүй болон хагарсан цүлхэнгийн судсан дотуурхи мэс засал 3. Гавлын гаднах артерийн судасны нарийсалд стент тавих мэс засал 4. Гавлын доторхи артерийн судасны нарийсалд стент тавих мэс засал 5. Тархины судасны артери-вейн судасны мальформацийг судсан дотроос бөглөх мэс засал 6. Тархины цус тасалдах харвалттай өвчтөнд судсан дотроос механик тромбэктоми хийх мэс засал 7. Гэмтлийн шалтгаант дураль хальсны артерийн венийн фистулийг судсан дотроос бөглөх мэс засал Тайлант хугацааны хэрэгжилт 80%
--	---	--

	2.5 Хэрхийн эмгэг, андрологи, бөөр орлуулах эмчилгээний үе дэх эмийн эмчилгээний арга, аргачлалыг нэвтрүүлэх /11 технологи/ 1. Бөөрний чулууны болон түрүү булчирхайн мэс заслын лазер эмчилгээг хөгжүүлэх 2. Бөөр шээсний замын гаж хөгжлийн нөхөн сэргээх мэс заслыг хөгжүүлэх 3. Андрологийн чиглэлийн эмийн эмчилгээг нэвтрүүлэх 4. Эрэгтэйчүүдийн үргүйдлийн оношилгоо эмчилгээний технологи 5. Бөөр шээсний замын уян дурангийн оношилгоо, эмчилгээг нэвтрүүлэх 6. Архаг диализийн өвчтөнүүдийн байнга хэрэглэдэг эмүүдийг (фосфор холбогч, кальцимемитик, кальцитрол	Нэвтрүүлж, хөгжүүлсэн технологийн төрөл, эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн үр дүн нэр тоо, тоо,	Тус ажлын хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн: 1. Бөөрний чулууны болон түрүү булчирхайн мэс заслын лазер эмчилгээг хөгжүүлэх чиглэлээр “Олон Улсын Ротарийн Глобал Грант” төслийн санхүүжилтээр 227.800 ам.долларын үнэ бүхий лазер аппарат, тоног төхөөрөмжийг УНТЭ-ийн Урологи-Андрологийн төвд нийлүүлэгдсэн. Бөөрний чулууны болон түрүү булчирхайн мэс заслын лазер эмчилгээг хийж нутагшуулаад байна. 2. Бөөр шээсний замын гаж хөгжлийн нөхөн сэргээх мэс заслыг бүрэн нутагшуулсан. 3. Урологи-Андрологийн төв нь андрологийн чиглэлийн эмчилгээнд хэрэглэгддэг 4 төрлийн эмийг тусламж үйлчилгээнд хэрэглэх саналыг ЭЭХХЗГ-т хүргүүлж 2023 оны байдлаар 3 эмийг ЭХНБ-ууд албан ёсоор бүртгэлжүүлэн импортолж оруулж ирээд байна. 4. УАТ-ийн амбулаторийн хэсэгт андрологийн чиглэлээр шинжилгээ, оношилгоо хийгдэх тоног төхөөрөмж болох урофлоуметрийн аппарат, центрфугийн хамт суурилуулж кабинетыг иж бүрэн тохижуулсан бөгөөд шээсний доод замын хөдлөл зүй, үргүйдлийн эмгэгийг оношлох, шинжлэх шинжилгээний аргыг 2021 онд бүрэн нэвтрүүлсэн. Мөн үрийн сувгийг тайраад залгах, үрийн сувгийг төмсгөнд залгах, төмсөгнөөс эр бэлгийн эс авах, үрийн сувгийг төмсөгний дайварт залгах мэс заслууд тогтмол хийгдэж байна. 5. Бөөр шээсний замын түвэгтэй, хүнд хэлбэрийн чулууны үед 360 градус эргэж чулууг авах боломжтой уян дурангийн мэс заслын өндөр технологийг УАТ нь тусламж үйлчилгээндээ бүрэн нэвтрүүлсэн. 6. УНТЭ-ийн Бөөрний төвийн гемодиализын хэсгийн тусламж үйлчилгээг 2020-2021 онд хувийн байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээ байгуулж МЕДВИК ХХК-нд бүрэн шилжүүлж өгсөн. Үүнтэй холбоотойгоор тус эмнэлгийн
--	---	--	--

	г.м) Монгол Улсын эмийн бүртгэлд оруулж, ЭМД-ын хөнгөлөлтөнд хамруулах 7. Хэрхийн эмгэгийн үеийн оношилгоонд Ultrasonography /synovial membran/ шинжилгээг нэвтрүүлэх 8. Хэрхийн эмгэгийн үеийн оношилгоог сайжруулах оношилгооны урвалжийг тогтмол, хүртээмжтэйгээр хангах, ЭЭСНЛ-т оношилгоог нэвтрүүлэх /Anti CCP, Anti-nuclet-antibody, ANCA p end c, profile, HLA-B27, HLAB51/ 9. Хэрхийн эмгэгийн орчин үеийн эмчилгээний бэлдмэлүүд болох /DMARD/ циклофосфамид, гидрооксихлорхинин, биологийн агентууд Т эсийн гадаргууны молекулын эсрэг, Цитокининий эсрэг @-anti-TNF(etaner, infliximab, addimab), Т-эсийн идэвхжсэн антигенд нөлөөлөх бэлдмэлүүд, Т болон В эсийн харилцан үйлчлэлд нөлөөлөх Т эсээр вакцинжуулах, генийн эмчилгээ зэрэг эмчилгээний бэлдмэлийг практикт нэвтрүүлэх		Бөөрний төв нь архаг диализийн өвчтөнүүдийг хянах чиг үүрэггүй болсон. 7. Хэрхийн эмгэгийн үеийн оношилгоонд Ultrasonography /synovial membran/ шинжилгээг нэвтрүүлэх төсөл бичигдсэн, үе судлалын эмч эхоны сургалтанд хамрагдсан. 2023 оны байдлаар 6 сард Францын Ревматолог эмч ДР. ХУБЕРТ эмчтэй хамтарч үений эхоны анхан шатны ажлын байран дээрхи сургалт зохион байгуулсан. УНТЭ-Хэрх үе судлалын хэсэг нь яс үений эхотой болсон. Шаардлагтай хяналтын өвчтөнүүдэд хүний нөөцийн байдалтай холбоотойгоор бага хэмжээгээр хийж байна. 8. Хэрхийн эмгэгийн үеийн оношилгоог сайжруулах оношилгооны урвалжийг тогтмол, хүртээмжтэйгээр хангах, ЭЭСНЛ-т оношилгоог нэвтрүүлэх чиглэлээр улиралд 1-2 удаа Anti CCP, Anti-nuclet-antibody, ANCA p end c зэрэг үзүүлэлтүүдийг үзэж байгаа. (profile, HLA-B27, HLAB51 зэрэг үзүүлэлтүүд хийгдэхгүй байна) 2023 оны байдлаар HLA-B27 шинжилгээг хангалттай тоогоор УНТЭ –н лабораторт хийгдэж байна. Anti-ccp, ANA, anca-p,c шинжилгээнүүдийг цөөн тоогоор хийж байгаа боловч хүртээмж муутай хэвээр байна. 9. 2022 онд Хэрхийн эмгэгийн орчин үеийн эмчилгээний бэлдмэлүүд болох DMARD эмчилгээнээс циклофосфамидийг эмчилгээнд нэвтрүүлсэн бусад эмчилгээг хийж эхлээгүй. Бай эмчилгээ нэвтрүүлээгүй. 2023 онд ЭМЯ-с УНТЭ-т ковид19-н шугамаар Tocilizumab – IL 6 inhibitor Bdmard эмчилгээг өгсөн. Дээрхи эмийг холбогч эд системийн эмгэг оноштой 11 хүнд 4 долоо хоногийн зайтай 4-8 тун эмчилгээ анх удаа амжилттай хэрэглэсэн. Мөн цөөн тоогоор IL-17 , CD20 inhibitor эмчилгээг шаардлагатай өвчтөнүүдэд хэрэглэж байна. Улсын хэмжээнд гол шаардлагатай anti-TNF эмчилгээ одоо хүртэл бүртгэгдээгүй хэвээр байна. Тайлант хугацааны хэрэгжилт 80%
--	---	--	---

	2.6 Мэдээгүйжүүлгийн болон архаг өвдөлтийн үеийн технологийн менежментийг хөгжүүлэх /4 технологи/ 1. Архаг өвдөлтийн менежментийг сайжруулах, ЭХО болон C-arm аппараттай өвдөлт намдаах ажилбаруудын нэр төрлийг нэмэгдүүлэх 2. Төвөгтэй интубаци болон ам ангайлтгүй өвчтөнд бронхоскопийн тусламжтайгаар интубацийг мэдээгүйжүүлгийн эмч нар хийх технологийг нутагшуулах	Нэвтрүүлж, хөгжүүлсэн технологийн нэр тоо, төрөл, эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо, үр дүн	Тус ажлын хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн бөгөөд 2020-2023 онд хэрэгжилтийг 95%-тай байхаар тооцсон. 2023 оны жилийн эцсийн байдлаар тус хэсгийн хэрэгжилтийг нийт 90%-тай байна. 1. Архаг өвдөлтийн менежментийг сайжруулах, ЭХО болон C-arm аппараттай өвдөлт намдаах ажилбаруудын нэр төрлийг нэмэгдүүлэх ажил бүрэн хэрэгжсэн, жилд 2000 тохиолдол хийж байна. 2. Төвөгтэй интубаци болон ам ангайлтгүй өвчтөнд бронхоскопийн тусламжтайгаар интубацийг мэдээгүйжүүлгийн эмч нар хийх технологийг ГЭТ-тын дурангийг эмч нартай хамтран хийж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	2.7 Уламжлалт, сэргээн засах эмчилгээний технологийг өргөжүүлэн хөгжүүлэх /8 технологи/ 1. Уламжлалт сэргээн засах чиглэлээр туйплан эмчилгээг бөөрний төвтэй хамтран нэвтрүүлэх, үйлчилгээний үр дүн хурдан үзүүлдэг галтай зүү эмчилгээг бие даан нэвтрүүлэх	Нэвтрүүлж, хөгжүүлсэн технологийн нэр тоо, төрөл, эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо, үр дүн	Уламжлалт, сэргээн засах чиглэлээр туйплан эмчилгээг бөөрний төвтэй хамтран нэвтрүүлэх ажил хэрэгжээгүй. Сэргээн засах, уламжлалт эмчилгээний тасгийн их эмч Ц.Дэнсмаа 2023 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын ОУМЭ-т уламжлалт анагаах ухааны мэргэжил дээшлүүлэх 3 сарын сургалтанд хамрагдсан бөгөөд үйлчилгээний үр дүн хурдан үзүүлдэг галтай зүү эмчилгээг бие даан нэвтрүүлэх боломж бүрдсэн. Тайлант хугацааны хэрэгжилт 20%
3.Олон улсын үйлчилгээний менежмент, дэвшилтэт технологийг нэвтрүүлэн нутагшуулах	3.1 Олон улсын эмнэлгүүдийн үйлчилгээний менежментийн сайн туршлагыг нутагшуулан хөгжүүлэх	Зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын тайлан, нутагшуулан хөгжүүлсэн менежментийн арга барилууд, гарсан үр дүн	Хэрэгжилтийг үнэлэх боломжгүй. Шинэчлэн батлуулах стратеги төлөвлөгөөнд тусган батлуулах.
	3.2 ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн хэсгүүдэд тасралтгүй сайжруулалтыг хийж, давтан баталгаажуулж, хэвтэн	Магадлан итгэмжлэлд орсон ажлын тайлан, итгэмжлэлийн гэрчилгээ, гарсан үр дүн	УНТЭ 2023 онд ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх, баталгаажуулалтын аудит хийлгэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний компани болох “УАЙ

	эмчлүүлэх хэсэгт шинээр нэвтрүүлэн нутагшуулах		ЭС КОНСАЛТИНГ” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажилласан. 2023 оны 12 сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд нийт 39 алба, төв, тасаг, нэгжийн 125 эмч, сувилагч, мэргэжилтнүүдийг хамруулан 6 удаагийн цуврал сургалт, удирдлагуудад 2 удаагийн, дотоод аудитор бэлтгэх сургалтыг тус тус зохион байгуулсан. - ЧМТ MNS ISO 9001:2015 стандартын дотоод аудитын шалгалтад хамрагдан аудиторын эрх авсан 32 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээс гэрээт зөвлөхүүдтэй хамтран 22 нэгжид хяналт үнэлгээ хийсэн. - Нийт 41 алба, төв, тасаг нэгжийн 634 чиг үүрэг, процесс зурагдаж эмнэлгийн захирлын 2023 оны А/137 тоот “Алба, төв, тасаг, нэгжийн чиг үүрэг, үйл явцын зураглалыг батлах тухай” тушаалаар батлагдсан. - ЧМТ MNS ISO 9001:2015 стандарт шаардлагын дагуу 14 журмыг шинэчлэн боловсруулж батлуулсан. УНТЭ нь 2023 оны 12 дугаар сард Мон Майнинг Сертификейшн ХХК-тай баталгаажуулалтын үйлчилгээний гэрээ байгуулан 11-12-ны өдрүүдэд баталгаажилтын аудитад хамрагдан 3 жилийн хугацаатай итгэмжлэгдсэн. Тайлант хугацааны хэрэгжилт 100%.
	3.3 Үйлчлүүлэгчийн хэрэгцээнд тулгуурлан үйлчилгээний менежментийг тасралтгүй сайжруулж, үйлчлүүлэгчээ тогтмол судлах тогтолцоог хэрэгжүүлэх	Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авах тогтолцоог хялбаршуулах чиглэлээр хийсэн ажлын тайлан, үр дүнгийн чиглэлээр хийх сайжруулалтын төлөвлөгөө, тайлан	ЭМТҮЧАБА-аас ЭМС-ын 2022 оны А/346 тоот “Журам шинэчлэн батлах” тухай тушаалын дагуу хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг эрүүл мэндийн байгууллагууд судалгаа 1313.mn холбоосоор нэвтэрч орон, өөрийн байгууллагад хамаарах QR код үүсгэн судалгааг авч байна. Шинээр өөрийн байгууллагын үйлчлүүлэгчийг тогтмол судлах, үйлчлүүлэгчийн хэрэгцээг тогтмол тодорхойлох чиглэлээр тодорхой ажил зохион байгуулаагүй боловч иргэдэд ээлтэй тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх чиглэлээр 11.00 ажлын хэсгийг байгуулан тусламж үйлчилгээний зохион байгуулалтыг сайжруулах, засвар хийж үйлчлүүлэгчийн үйлчилгээ авах орчин нөхцөлийг тав тухтайгаар бүрдүүлэх, үйлчилгээг цахимжуулах, ил тод нээлттэй болгох, ажилтнуудын ажлын цаг ашиглалтыг сайжруулах, хаяг хаягжилтийг нэмэгдүүлэх, угтах, чиглүүлэх үйлчилгээг үр дүнтэй болгох ажлуудыг тасралтгүй зохион байгуулж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%.

	3.4 Эмнэлгийн байгууллагын үйлчилгээний ажилтны /угтан чиглүүлэх, цахим бүртгэлийн болон бусад/ үйлчилгээнд тавигдах стандарт хэм хэмжээг боловсруулж, байгууллагын стандартаар бүртгүүлж, баталгаажуулан мөрдөж ажиллах	Батлагдсан журам, баталгаажсан стандарт, үйлчилгээний ажилтнуудын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээ	Эмнэлгийн захирлын 2020 оны А/126 тоот “Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн угтан чиглүүлэх, цахим бүртгэлийн үйлчилгээний журам”-ыг баталсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тусламж үйлчилгээний газраас боловсруулан баталсан эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан болон үйлчлүүлэгчид даган мөрдөх “Эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний стандарт MNS 7014:2023” стандартыг нэвтрүүлж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%.
4.Байгууллагын чадамжид суурилан эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг үндэсний хэмжээнд сайжруулах	4.1 Орон нутаг, дүүргийн эмнэлгийн мэргэжилтний чадамжийг дээшлүүлэх “Салбарын хөгжилд хамтдаа” төслийг хэрэгжүүлэх	Төсөлд хамрагдсан аймгуудын болон УБ хотын алслагдсан дүүргүүдийн эмнэлгүүдийн тоо, чадавхижуулах сургалтанд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоон судалгаа, төслийн тайлан, гарсан үр дүн	Тайлант хугацаанд буюу 2020-2024 онуудад УНТЭ нь хөдөө, орон нутаг, алслагдсан дүүргийн эмнэлгүүдийн эмч мэргэжилтнүүдийг чадавхижуулах, сургах, төвлөрлийг сааруулах, хүлээгдэл чирэгдлийг бууруулах зорилго бүхий “Салбарын хөгжилд хамтдаа” төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн томоохон ажлуудаас дурьдвал: 1. УНТЭ нь Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг үндсэн мэргэшлийн нийт 11 чиглэлээр, төрөлжсөн болон дээшлүүлэх сургалтын нийт 57 чиглэлээр зохион байгуулдаг бөгөөд 2020-2024 онд үндсэн, төрөлжсөн мэргэшлийн болон мэргэжил дээшлүүлэх сургалтаар нийт 2548 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг улсын хэмжээнд бэлтгэн, УБ хотын 9 дүүрэг, орон нутгийн болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг бусад эрүүл мэндийн байгууллагуудыг чадавхижуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулахад чиглэж ажилласан байна. Үүнд: ➢ Үндсэн мэргэшлийн буюу резидент эмч 731, ➢ Төрөлжсөн мэргэшлийн эмч 333 ➢ Төрөлжсөн мэргэшлийн сувилагч, тусгай мэргэжилтэн 590 ➢ Мэргэжил дээшлүүлсэн эмч 447 ➢ Мэргэжил дээшлүүлсэн сувилагч, тусгай мэргэжилтэн 447 бэлтгэгдсэн байна. Нийт суралцагчдын 60 гаруй хувь нь хөдөө орон нутгаас суралцаж төгссөн бөгөөд суралцан төгссөн чиглэлээрээ орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллаж байна.
	4.2 Орон нутгийн үйлчлүүлэгчийн хүлээгдэл, чирэгдлийг бууруулах, төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг орон нутагтаа авахад чиглэгдсэн мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах	Хүлээгдэл чирэгдлийг бууруулсан он оны тайлан мэдээ, зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын тайлан, мэргэжил арга зүйгээр хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан, сургаж бэлтгэсэн эмч, мэргэжилтний тоо	

			2. 2023-2024 онд Бөөр шилжүүлэн суулгах чиглэлээр Цэргийн төв эмнэлгийн 27 эмч, сувилагчийг, УХТЭ-ийн 90 эмч, сувилагчийг ажлын байрны дагалдан сургалтад хамруулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна. 3. УНТЭ-ийн Урологи-Андрологийн төв нь тайлант хугацаанд орон нутгийн 15 аймагт бөөр шээсний доод замын дурангийн мэс заслыг нутагшуулж, багаж тоног төхөөрөмжийн хангалт хийн, эмч сувилагч нарыг бэлтгэж өгсөн. Мөн ХСҮТ, Цэргийн төв эмнэлэгт, Баянгол дүүргийн эмнэлэг, УГТЭ зэрэг эмнэлэгүүдэд сургалт арга зүйн зөвлөгөө тогтмол өгч байна. 2020 онд УГТЭ болон УХТЭ-т бөөрний мэс заслын тасгийг шинээр байгуулж 2 эмч очиж 1 жилийн хугацаатай ажилласан. 4. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 06 сарын 30-ны өдрийн А/344 тоот тушаалын дагуу УНТЭ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн баг Баянхонгор, Говь-Алтай, Төв, Архангай, Өвөрхангай аймаг болон нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй, Хан-уул дүүргийн эмнэлгүүдтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан шаардлагатай чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургаж чадавхижуулсан. 5. УНТЭ-ийн Нүд судлал, мэс заслын тасаг нь Орбис олон улсын байгууллагатай хамтран Ховд, Увс, Хөвсгөл, Сэлэнгэ, Баянхонгор, Сүхбаатар, Орхон аймгийн нүдний эмч нарыг жижиг зүслэгт болрын мэс засалд сургах төсөл хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн. Энэ хөтөлбөрийн хүрээнд тус 7 аймгийн нүдний эмч нарт мэс заслын аргыг ажлын байранд нь зааж сурган орон нутгийн иргэдийг орон нутагтаа чирэгдэлгүйгээр тусламж үйлчилгээнд хамрагдах нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн Чих, хамар, хоолой судлал, НСМЗТ-ийн эмч нар нь Канад улсын Лаурел Сан, АНУ-ын Вирту Сантай тайлант хугацаанд тогтмол хамтран ажиллаж орон нутгийн нүдний эмч нарыг чих, хамар хоолой, нүдний бусад мэс заслын чиглэлээр танхимийн болон ажлын байрны сургалтыг тогтмол зохион байгуулж чадавхижуулж байсан. 6. УНТЭ-ийн Бөөрний төв нь улсын хэмжээний лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлдэг бөгөөд БНСУ, БНХАУ, Япон улсуудтай бөөрний эмгэгийн чиглэлээр тогтмол хамтран ажиллаж иргэдэд учирч буй чирэгдэлийг бууруулах зорилгоор хүнд, МУ-д ховор тохиолддог эмгэгүүдийн үед цаг хугацаа алдалгүйгээр онлайн
--	--	--	---

		вебинар зохион байгуулан гадны орны профессоруудаас зөвлөгөө аван тусламж үйлчилгээ үзүүлдэг. Мөн алслагдсан орон нутаг, аймаг, дүүргийн эмнэлгүүдийн эмч нарт бөөрний өвчний нарийн мэргэжлийн чиглэлээр алсын зайн зөвлөгөөн хийж үйлчлүүлэгчийн тусламж, үйлчилгээг хурдан бөгөөд оновчтой шийдвэрлэхэд туслалцаа үзүүлж ажилладаг. 7. УНТЭ-ийн Бүдүүн шулуун гэдэс, мэс заслын тасгийн эмч нар нь тайлант хугацаанд бүдүүн шулуун гэдэсний мэс заслын чиглэлээр хөдөө орон нутгийн эмч нарыг чадавхижуулах сургалтыг тогтмол зохион байгуулсан. 8. УНТЭ-ийн Сувилахуйн алба, Эрчимт эмчилгээний тасгийн сувилахуйн багийн хамт олон хамтран эрчимт эмчилгээний сувилахуйн тусламжийн чиглэлээр ажиллаж байгаа сувилагч нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор “Эрчимт эмчилгээний сувилахуй-2 Амилуулах суурь тусламж” сэдэвт цуврал багц цагийн сургалтыг 2024 оны 4-р сард амжилттай зохион байгуулж, сувилахуйн багийн үйл ажиллагаанд шинээр нэвтэрч буй CRRT, ЕСМО зэрэг технологиуд, төрөлжсөн сувилахуйн тусламж үйлчилгээний өнөөгийн чиг хандлагын талаар мэдээллүүд хийгдэж УНТЭ, УХТЭ, УГТЭ, ГССҮТ, ХСҮТ, ХӨСҮТ, ЦТЭ, ЦСҮТ, Багануур нэгдсэн эмнэлэг, хөдөө орон нутгаас Өвөрхангай, Хэнтий, Дархан-Уул, Орхон, Архангай, Баянхонгор, Төв, Дорноговь, Хөвсгөл, Увс, Дундговь, Говь-Алтай аймгуудаас нийт 160 гаруй сувилагч хамрагдсан. Элэг шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний чиглэлээр УХТЭ-ийн Сувилахуйн алба нь дарга, арга зүйч, ахлах сувилагч, сувилагч нарын хамтаар хүрэлцэнэ ирж суралцсан. Тайлант хугацааны хэрэгжилт 100%.
	4.3 Зайн оношилгоо, эмчилгээ, зайн сургалтыг өргөжүүлэн хөгжүүлэх замаар орон нутгийн эмнэлгийн мэргэжилтний тусламж үйлчилгээний чадамжийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Зайн оношилгооны чиглэлээр зохион байгуулах сургалтын жил бүрийн батлагдсан төлөвлөгөө, тайлан, сургалтанд хамрагдсан эмч мэргэжилтний тоо, 2022 оноос эхлэн олон улсын зайн оношилгооны төсөл зогссон тул хэрэгжилтийг үнэлэх боломжгүй.

		гарсан үр, хөдөө орон нутагт нэвтрүүлсэн технологийн тоо	
	4.4 Эмнэлгийн тусламж үйлчилгээний ачааллыг бууруулсанаар эмчилгээ, оношилгооны шинэ технологийг хөгжүүлэхэд анхаарал хандуулж ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх	Хийсэн ажлын тайлан, гарсан үр дүн, тусламж үйлчилгээний ачааллыг бууруулж орон нутгийн эмнэлгүүдийг чадавхижуулсан төсөл хөтөлбөрүүд	Тайлант хугацаанд тоног төхөөрөмж, төсөв санхүү, хүний нөөц нь бэлтгэгдсэн эмчилгээ, оношлогооны 200 гаруй технологийг нэвтрүүлж, нутагшуулсан. Тайлант хугацааны хэрэгжилт 100%.
5.Нийгмийн эрүүл мэндийн шинэ технологи, сайн туршлагыг нутагшуулах	5.1 Зонхилон тохиолдох халдварт бус өвчний мэдээллийн нэгдсэн сан, өгөгдлийг бий болгох	Үүсгэсэн бүртгэл мэдээллийн сан, батлагдсан үйл ажиллагааны журам	Зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлууд: УНТЭ-ийн Эрүүл мэндийг дэмжих төвд Эрүүл мэндийн Сайдын 2022 оны А/139 тоот тушаалаар баталсан “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах” журмын дагуу Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн хуваарилагдсан хороодын иргэдийг эрт илрүүлэгт хамруулсан. Мөн хүсэлт тавьсан байгууллагуудын ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж бүртгэл мэдээллийн сан үүсгэсэн. 2022 оны жилийн эцсийн байдлаар улс орон даяар байгуулагдсан эрт илрүүлэгт СБД, ЧД-ийн хуваарилагдсан хороодын иргэдийн эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулж нийт 3357 иргэдийг хамруулсан. 2023 оны жилийн эцсийн байдлаар Сүхбаатар дүүргийн 1,2,3,4,5,6-р хороо, Чингэлтэй 17, 19-р хорооны 3775 иргэн хамрагдсан буюу СБД-с 1074 иргэн, ЧГД-ээс 2124 иргэн хамрагдаж бүртгэл мэдээллийн нэгдсэн санг батлагдсан маягтын дагуу үүсгэсэн. Урьдчилан сэргийлэх үзлэгт 6 байгууллагын 661 ажилтан хамрагдсан байна. 2024 онд 10 байгууллагын 4157 ажилтны урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж үзлэгийн дүнг албан байгууллага болон ажилтнуудад хүлээлгэн өгсөн. 2024 оны 01-р сарын 01-ээс 2024 оны 11-р сарын 30-ны байдлаар нийт 1316 иргэн эрт илрүүлэгт хуваарийн дагуу хамрагдсан буюу СБД-с 159 иргэн, ЧГД-с 652 иргэн, бусад дүүргийн 511 иргэн хамрагдаад байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%.

	5.2 Үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх	Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэн ажиллах батлагдсан шалгуур үзүүлэлтүүд, хэрэгжилтийн тайлан жил бүрээр	УНТЭ нь 2020-2024 онд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй дараах арга хэмжээний төлөвлөгөөнүүдээс эрүүл мэндийн байгууллага болон УНТЭ-ийн үйл ажиллагаатай шууд холбоотой арга хэмжээнүүдийг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж, тайлан мэдээг хуулийн хугацаанд нь ЭМЯ-ны НЭМГ-т хүргүүлж байна. 1. “Эх,хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 2. “Хавдрын эсрэг” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 3. “Харшлаас сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 4. “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 5. “Эрүүл идэвхитэй амьдрал” 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 6. “Халдварт өвчинтэй тэмцэх,сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө батлах тухай 7. “Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 8. “Сэтгэцийн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 9. “Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх, хамгааллын (2024-2026 он) арга хэмжээний төлөвлөгөө” батлах тухай 10. “Эрүүл мэндийн салбарт жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлого, 2021-2024 онд бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө Тайлант хугацааны хэрэгжилт 100%.
--	--	---	---

ТЭРГҮҮЛЭХ СТРАТЕГИ 3. БАЙГУУЛЛАГЫН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАХ МЕНЕЖМЕНТИЙН АРГА БАРИЛЫГ НЭВТРҮҮЛЭН, САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ

ЗОРИЛГО: Байгууллагын санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн менежмент, гүйцэтгэлийн удирдлагыг сайжруулах замаар санхүүжилтын олон талт эх үүсвэрийг дэмжсэн уян хатан тогтолцоог хөгжүүлэхийг эрмэлзэж ажиллахад оршино.

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ЗОРИЛТ	ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ	ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН, ҮНЭЛГЭЭ
1.Байгууллагын чиг үүрэгтэй уялдсан засаглалын тогтолцоог бэхжүүлэх	1.1 Чиг үүрэгтэй уялдсан санхүүжилтийг бүрдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн нэр төрөл, тоо, гарсан үр дүн, жил бүрийн хэрэгжилтийн тайлан	Улсын нэгдүгээр төв эмнэлэг 2020 оны 01 дүгээр сард 9 хүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн удирдах зөвлөлтэй болсноор санхүүгийн хувьд хагас бие даасан байдалд шилжсэн. МУ-ын ЗГ, ЭМЯ-ны дэмжлэгтэй АХБ-ны “Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг сайжруулах төсөл” хэрэгжсэн. 2022 оноос байгууллагын засаглалын тогтолцоог бэхжүүлэх үүднээс ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэхээр ажлыг хэсэг байгуулан ажилласан бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Баталгаажилтын гэрчилгээ гардан авсан байна. Эмнэлзүйн үйл ажиллагааны чиглэлээр 2021-2024 онд Урологи-Андрологийн төв нь Шинжлэх ухаан технологийн сангийн дэмжлэгтэйгээр “Бөөр шээсний замын чулуу өвчний эрсдэлт хүчин зүйл тархвар зүйн судалгаа” 47.0 сая төгрөгийн төслийг амжилттай хэрэгжүүлж үр дүнгээ хүлээлгэж өгсөн. Мөн ЭЭСНЛ нь 2024 онд Шинжлэх ухаан технологийн сангийн дэмжлэгтэйгээр “Бөөрний эсийн өмөнгийн хэв шинжүүдийг радиологи-генетикийн (radiogenomic analyze) шинжилгээгээр харьцуулан судлах нь” 120.1 сая төгрөгийн төслийг хэрэгжүүлж байна. 2024 онд Эм зүйн алба, ЭМТҮЧАБА-дууд хамтран Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэй “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх дэлхийн 7 хоног” 17.5 сая төгрөгийн төслийг амжилттай хэрэгжүүлж дууссан. Тайлант хугацааны хэрэгжилт 90%
	1.2 Байгууллагын үйл ажиллагааны статистик үзүүлэлтэд суурилсан төлөвлөлт, хяналтын нэгдсэн системийг бий болгох	Нэгдсэн системийг бий болгох, зохицуулах, боловсруулж батлуулсан журам, гарсан үр дүн	2024 оны жилийн эцсийн байдлаар үүсгэн бий болгосон байгууллагын үйл ажиллагааны статистик үзүүлэлтэд суурилсан төлөвлөлт хяналтын нэгдсэн систем байхгүй. 2019 оноос эхлэн санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлж эхэлсэн Veritech ERP системд 2023 онд эм эмнэлгийн хэрэгслийн орлого, зарлага, гэрээний бүртгэлийн үйл ажиллагааг автоматжуулан эмнэлгээр үйлчлүүлэгчийн үйлчилгээ авсан онош оношийн хамааралтай бүлгийн санхүүжилт болон хэрэглэсэн эм, эмнэлгийн хэрэгслийн зарлагатай холбох ажлыг эхлүүлсэн. 2024 онд тус Veritech ERP системд шаардлагатай шалгуур үзүүлэлтийг нэмж эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа материалыг эхэлж авсанаа эхэлж зарлагдах аргад бүрэн шилжүүлсэн, үндсэн хөрөнгийг бар

			кодны системд оруулж тооллогыг бар код уншуулан тоолохоор тохируулсан мөн гэрээ, гэрээний гүйцэтгэл бүрэн гардаг болсон ба Санхүүгийн Veritech системд нягтлан бодох бүртгэлийн модуль тус бүрээр нь шаардлагатай хөгжүүлэлтийг нэмж хийн 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар шалгуурыг ажиллуулж 3-р улирлын тайлан тэнцэл дээр туршиж дуусгасан. Тус Veritech ERP smart системд байгуулаллагын үйл ажиллагааны статистик үзүүлэлт болон санхүүгийн үйл ажиллагааг уялдуулсан санхүүгийн нэгдсэн дашбоардын модуль байгаа бөгөөд нэмэлт хөгжүүлэлтийг эрүүл мэндийн яамны ажлын хэсгээс нэгдсэн журмаар хийх шийдвэр гарсан тул хүлээж байгаа болно. Тайлант хугацааны хэрэгжилт 90%
	1.3 Санхүүгийн тогтвортой байдлаа хадгалах чиг үүргийн эрх зүйн орчны шинэчлэл, өөрчлөлтөд манлайлан оролцох	Хийсэн ажлын тайлан, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, гарсан үр дүн	УНТЭ нь ЭМЯ, СЯ, ЭМДЕГ-аас чиглүүлэн зохион байгуулсан эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжих бэлтгэл ажлын хүрээнд даатгалын санхүүжилтийн өртөг тооцох болон бусад шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргаж өгөх ажилд идэвх санаачлагатай оролцсон. ЭМДҮЗ-өөс баталсан тушаал шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар мэс заслын тусламж үйлчилгээ, цөмийн онош зүйн тусламж үйлчилгээ, лабораторийн шинжилгээ, зүрхний тусламж үйлчилгээний өртөгүүдийг тус тус тооцсон. Тайлант хугацааны хэрэгжилт 70%
2.Санхүүгийн бүрдүүлэлтийн тогтолцоог сайжруулах	2.1 ЭМД-ын санхүүжилтийг 173%-иар нэмэгдүүлэх.	Эмнэлгийн тусламж үйлчилгээний менежмент сайжирсан байна.	2024 оны жилийн эцсийн байдлаар эмнэлэг нь гүйцэтгэлийн санхүүжилтэнд шилжсэнээр байгууллагын нийт төсөв ➤ 2020 онд 23,9 тэрбум, ➤ 2021 онд 49,9 тэрбум, ➤ 2022 онд 74,4 тэрбум, ➤ 2023 онд 76,9 тэрбум, ➤ 2024 онд 78,9 тэрбум болсон ба ЭМД-ийн санхүүжилт 195%-иар нэмэгдсэн байна

			 ЭМД-ын санхүүжилт <table><tr><td>2020 он</td><td>2021 он</td><td>2022 он</td><td>2023 он</td><td>2024 он</td></tr><tr><td>23,992,951,200</td><td>49,997,151,700</td><td>74,404,993,200</td><td>76,953,895,632</td><td>78,940,143,026</td></tr></table> Тайлант хугацааны хэрэгжилт 100%	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	23,992,951,200	49,997,151,700	74,404,993,200	76,953,895,632	78,940,143,026
2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он									
23,992,951,200	49,997,151,700	74,404,993,200	76,953,895,632	78,940,143,026									
2.2	Үндсэн үйл ажиллагааны орлогыг 60%-иар нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны менежмент сайжирсан байна.	УНТЭ-ийн үндсэн үйл ажиллагааны орлого нь ➤ 2020 онд 3,1 тэрбум, ➤ 2021 онд 3,5 тэрбум, ➤ 2022 онд 5,2 тэрбум, ➤ 2023 онд 5,4 тэрбум, ➤ 2024 онд 4,8 тэрбум болсон ба үндсэн үйл ажиллагааны орлого 54 %-иар нэмэгдсэн байна. Мөн ЭМДҮЗ-ийн тогтоолын дагуу тусламж үйлчилгээний санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой иргэнээс гарах хувь хэмжээнд өөрчлөлт орсон. Тайлант хугацааны хэрэгжилт 90%										
2.3	Төлбөрийг хариуцах үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх	төрөөс тусламж 40%-иар	Эмнэлгийн тусламж үйлчилгээний цар хүрээ өргөжсөн байна 2020 оноос эхлэн эрүүл мэндийн байгууллагууд нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжээд эрүүл мэндийн даатгалын сангаас нийт санхүүжилт хийгдэж байгаа бөгөөд төлбөрийг нь төр хариуцах эрхтэн шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээнд онцгой анхааран санхүүжилтийн хэмжээг тухайн жилийн инфляцитай уялдуулан өсгөхөөр саналыг удаа дараа Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн. Цаашид төлбөрийг төр хариуцахад төсөвлөгдсөн дархлаа дарангуйлах эм нь өөрөө тус эмнэлгийн үндсэн чиг үүрэг биш эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулгын газрын чиг үүрэгт шилжүүлэх нь зохистой байх нөхцөл байдал үүсээд байгаа бөгөөд 2024 оны 12 сарын 25-ны өдрийн байдлаар МУ-ын хэмжээнд 1200 эрхтэн шилжүүлэн суулгасан (элэг, бөөр, үүдэл эс) иргэний төлбөрийг нь төр хариуцах тусламжийн төсөвт 4.8 тэрбум төгрөг										

			төсөвлөгдсөн ба жилдээ тухайн үеийн ханш, зэргээс шалтгаалан гүйцэтгэл нь 7,8 тэрбум төгрөгт хүрч цаашид ч тогтмол өсөх хандлагатай байна. Энэ нь тусламж үйлчилгээний цар хүрээ өргөжсөн сайн талтай боловч гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэн эрүүл мэндийн байгууллагын чиг үүрэгт төдийлөн хамааралтай биш ажиглагдаж байна. Төр даах эмийн санхүүжилт <table><tr><th>Он</th><th>Хэмжээ</th></tr><tr><td>2021 он</td><td>3,991,643,510</td></tr><tr><td>2022 он</td><td>4,680,900,622</td></tr><tr><td>2023 он</td><td>5,264,128,642</td></tr><tr><td>2024 он</td><td>8,215,898,360</td></tr></table> Тайлант хугацааны хэрэгжилт 100%	Он	Хэмжээ	2021 он	3,991,643,510	2022 он	4,680,900,622	2023 он	5,264,128,642	2024 он	8,215,898,360
Он	Хэмжээ												
2021 он	3,991,643,510												
2022 он	4,680,900,622												
2023 он	5,264,128,642												
2024 он	8,215,898,360												
3. Санхүүгийн менежментийн тогтолцоог сайжруулах	3.1 Оновчтой төлөвлөлт, бодит гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг татах	Санхүүжилтийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр боловсруулж, хэрэгжүүлсэн бодлогын бичиг баримтын тайлан, гарсан үр дүн	Нийт эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнээр санхүүгийн оновчтой төлөвлөлт, бодлогыг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага бий болж УНТЭ-ийн Санхүү бүртгэлийн алба нь 2024 оны 05 дугаар сарын 27-ний өдөр Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-тай нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт боловсруулж өгөх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, төлбөрийг бүрэн барагдуулсан ба шинэчилсэн бодлогын баримт бичиг хэвлэлтэнд орсон байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%										
	3.2 Эмчилгээ, оношилгооны нэвтрүүлсэн шинэ технологитой холбогдсон өртөгийг Эрүүл мэндийн даатгалын санд тусган санхүүжилтыг нэмэгдүүлэх	Шинээр өртөг тооцсон ажлын тайлан, эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн хувь жил тутам нэмэгдсэн байх	УНТЭ нь гүйцэтгэлд суурилсан санхүүгийн тогтолцоог нэвтрүүлж, хагас бие даасан бүтцэд шилжсэнээр эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэл, оношийн бүлгээр санхүүжиж байна. ЭМДЕГ-тай байгуулсан гэрээний дагуу 516 оношийн хамааралтай бүлгээр тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Эмчилгээ, оношилгооны нэвтрүүлсэн шинэ технологитой холбогдсон өртгийг эрүүл мэндийн даатгалын санд тусган санхүүжилтыг нэмэгдүүлэх зорилгоор тусламж үйлчилгээний өртөгийг үе шаттайгаар тооцож Эрүүл мэндийн даатгалд өөрчлөлтийг оруулж ирсэн болно. Үүнд										

			➤ цусны хавдар, ➤ элэг, бөөр, цусны үүдэл эс шилжүүлэн суулгах хагалгаа, ➤ мэс заслын тусламж үйлчилгээ, ➤ амбулаторийн тусламж үйлчилгээ болон даатгалд ороогүй төлбөртэй тусламж үйлчилгээний өртөгийг шинэчилсэн. Мөн 2024 онд бүх мэс заслын тусламж үйлчилгээ болон цөмийн онош зүйн тусламж үйлчилгээ, лабораторийн шинжилгээ, зүрхний тусламж үйлчилгээний өртөгүүдийг тус тус тооцож ажилласан байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	3.3 Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын бүрдүүлэлт, үйлчлүүлэгчийн сонголтод тулгуурласан төлбөртэй тусламж үйлчилгээний менежментийг сайжруулах	Менежментийг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын, төлбөрт тусламж үйлчилгээний шинэчлэгдсэн журам, жил бүр нэмэгдсэн нэмэлт орлогын хувь	Эмнэлэгт үзүүлж буй төлбөртэй тусламж, үйлчилгээ Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49/А/118 дугаар тушаалаар зохицуулагддаг бөгөөд энэхүү тушаал хүчин төгөлдөр хэвээр байгаа. Тус тушаалд шинээр оруулах тусламж, үйлчилгээний жагсаалтыг Эрүүл мэндийн яаманд албан бичгээр хүргүүлсэн болно. Эрх зүйн орчин бүрдээгүй тул хэрэгжилтийг тооцох боломжгүй.
	3.4 VIP үйлчилгээтэй “Эрүүл мэндийг дэмжих төв” байгуулах	Төв байгуулагдаж үйл ажиллагаа нь жигдэрсэн байх, үйл ажиллагааг зохицуулсан тушаал шийдвэрүүд батлагдсан байх	Улсын Нэгдүгээр төв эмнэлэг нь олон улсын стандартад нийцсэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх чиглэлийн нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээ, оношилгооны иж бүрэн төв болох “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг 2020 оны 6-р сарын 22-ны өдөр бүрэн ашиглалтанд оруулж нээсэн. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	3.5 “Амбулаторийн эмийн сан” байгуулах	Эмийн сангийн үйл ажиллагаа жигдэрсэн байх, үйл ажиллагааг зохицуулсан тушаал	Улсын Нэгдүгээр Төв эмнэлэг нь хагас бие даасан байдалд шилжсэнтэй холбоотой 2020 онд “Хоёр талт буюу амбулаторийн эмийн сан”-г үйл ажиллагаанд оруулсан. Тус эмийн сангийн үйл ажиллагааны гол чиглэл нь ЭМДЕГ-тай “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ 2023.01.02-д байгуулан хөнгөлөлттэй болон эрүүл мэндийн даатгалаар олгох эмээр иргэдэд үйлчлэх бөгөөд иргэн амбулаториор үзүүлж

		шийдвэрүүд батлагдсан байх	бичигдсэн эмчилгээг эмийн сангуудаар хайж явдаг, заавал өрх дүүргийн эмнэлэг дээрээ очиж хөнгөлөлттэй эмийн жор бичүүлж авдаг байсан бол амбулаторийн эмийн сангаас цаг алдалгүй, хурдан шуурхай хөнгөлөлттэй үнээр эмчилгээг авах үйлчилгээг иргэдэд тодорхой хувиар ойртуулсан. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
4.Санхүүгийн гүйцэтгэл, үр ашгийн тооцоог хянах тогтолцооны системийг нэвтрүүлэх	4.1 Санхүүгийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын нэгдсэн программын шинэчлэл хийх	Програм шинэчлэгдсэн байх, гүйцэтгэгч байгууллагатай хамтран ажиллах гэрээ, гэрээний дүгнэлт, гарсан үр дүн	Тус эмнэлэг гүйцэтгэлээр санхүүжих тогтолцооны энэ үед санхүүгийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хангах зорилгоор санхүүгийн үйл ажиллагаандаа хэрэглэж байсан суурин emerald санхүүгийн системийг Veritech ERP smart систетээр сольж эхний ээлжинд шаардлагатай хөгжүүлэлтийг хийж дуусгасан бөгөөд эмнэлгийн үндсэн систем болох ehealth систем хоорондын өгөдөл солилцох хөгжүүлэлтэнд эрүүл мэндийн яам оролцох болсон тус хөгжүүлэлт хүрээд зогссон болно Тус ажлын хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар 100%-тай байхаар төлөвлөсөн бөгөөд хэрэгжилт 90%-тай байна.
	4.2 Санхүүгийн оновчтой, үр ашигтай хуваарилалт, зарцуулалт, үр өгөөжийн тооцоолол, хяналтын системийг сайжруулах	Зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын тайлан, санхүүгийн тайлан, гарсан үр дүн,	Зардлын хяналтыг сайжруулах зорилгоор санхүүгийн програмыг шинэчлэн нэвтрүүлэлт, хөгжүүлэлтийн шатанд явж байна. Гүйцэтгэлээр санхүүжих тогтолцооны түүхэн энэ үед 2020-2024 онуудад тогтмол үйл ажилгааны үр дүн ашигтай гарч тайлан тэнцэлд тусгагдсан байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	4.3 Санхүүгийн нөөц, эрсдэлийн сан бүрдүүлэх	Эрсдлийн үнэлгээний тайлан, нөөц бүрдүүлсэн мөнгөн дүн, чиглэл	Эрх зүйн орчин бүрдээгүй тул хэрэгжилтийг тооцох боломжгүй.
5.Гүйцэтгэлд суурилсан урамшууллын системийг хөгжүүлэх	5.1Эмнэлгийн ажилтнуудын гүйцэтгэлийг бодитой үнэлж, бүтээмжийг дээшлүүлэх	Гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт батлагдсан байх	Ерөнхий захирлын 2022.09.07-ны өдрийн А/270 тоот “Гэрээ байгуулах тухай” тушаалын дагуу “Эрүүл амьдралыг иргэн бүрт” ТББ-тай УНТЭ119/22 дугаар бүхий гэрээг байгуулан ажиллаж байна. Зарцуулах төсөв 19,9 сая төгрөг ба эмнэлгийн ажилчдын бүтээмж, үр дүнд суурилсан гүйцэтгэлийг үнэлэх журам, шалгуур үзүүлэлтийг боловсруулан хүлээлгэж өгөх ажлын хүрээнд байгууллагын үйл ажиллагааны үзүүлэлтэд дүн шинжилгээ хийсэн.
	5.2 Урамшууллын системийг нэвтрүүлэн ажилтнуудын сэтгэл	Урамшууллын үнэлгээний журам	2020 онд нийт ажилчдад бүтээмжийн урамшуулал 10%-ийг үндсэн цалингаас тооцож олгож эхэлсэн ба 2020 онд бүтээмжийн урамшуулалыг 30% болгож

	ханамжийг нэмэгдүүлж, тусламж үйлчилгээний чанар, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах	батлагдсан байх, ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааны хувь нэмэгдсэн байх, чанар шалгуур үзүүлэлт сайжирч, тусламж үйлчилгээний алдаа эрсдэл буурах	тус урамшуулалыг үндсэн цалинг өсгөх замаар шилжүүлэн үндсэн цалинг 30%-иар нэмэгдүүлсэн. 2023 онд хоол унааны мөнгийг 2500 төгрөгөөр, 2024 оны 1-р сарын 01-нээс 2500 төгрөгөөр тус тус нэмж хоногийн 10,000 төгрөг болгосон. 2024 оны 09-р сарын 01-нээс нийт сувилагч нарын үндсэн цалинг 27%-иар нэмэгдүүлсэн байна. Гүйцэтгэлийн санхүүжилтийн үр дүнд нийт ажилчиддаа 13 дахь сарын цалин 2022 онд 950,0 сая төгрөг, 2023 онд 3,5 тэрбум төгрөг, 33 ажилчинд орон сууцны урьдчилгаа тус бүр 30,0 сая төгрөг нийт 900,0 сая төгрөгийг, 2024 онд 1,4 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна. Засгийн газрын 5-р тогтоолын дагуу улирал тутам олгодог 60%-ийн үр дүн урамшууллыг журманд заасан хугацаанд эхний цалин дээр олгож хэвшүүлсэн байна. Үүнд: ➤ 2020 онд 763,2 сая төгрөг ➤ 2021 онд 892,6 сая төгрөг ➤ 2022 онд 1,1 тэрбум төгрөг ➤ 2023 онд 1,4 тэрбум төгрөг ➤ 2024 онд 1,5 тэрбум төгрөг тус тус олгосон байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
--	---	---	---

ТЭРГҮҮЛЭХ СТРАТЕГИ 4. СУРГАЛТ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ТҮВШИНГ ОЛОН УЛСЫН ЖИШИГТ ХҮРГЭХ

ЗОРИЛГО: Олон улсын эрүүл мэндийн байгууллага, их сургуулийн эмнэлэг, боловсролын байгууллагуудын сургалтын загвар, дэвшилтэт арга барилыг төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхийн зэрэгцээ гадаад, дотоодын тэргүүлэх эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллаж судлаач, эмч эрдэмтдийн багийг бүрдүүлэн, эрдэм шинжилгээ, судалгааны хамрах хүрээг өргөжүүлж, судалгааны түвшинг дээшлүүлж, эрдэм шинжилгээ, судалгааг дэмжсэн үнэлгээ, урамшуулал, хяналтын тогтолцоог бий болгоход оршино.

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ЗОРИЛТ	ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ	ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН, ҮНЭЛГЭЭ
1.Төгсөлтийн дараах сургалтад суралцагчдын чадавхийг нэмэгдүүлэн, сургалтын нөхцөлийг сайжруулах орчин	1.1 Үндсэн, төрөлжсөн мэргэшлийн боловсролын байгууллагын менежментийн ISO21001 хэрэгжүүлэх сургалтад тогтолцоо стандарт	Зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын тайлан, магадлан итгэмжлэлийн гэрчилгээ	УНТЭ нь ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр зөвлөх үйлчилгээний компани болох “УАЙ ЭС КОНСАЛТИНГ” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажилласан бөгөөд 2023 оны 12 дугаар сард Мон Майнинг Сертификейшн ХХК-тай баталгаажуулалтын үйлчилгээний гэрээ байгуулан 12 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд баталгаажилтын аудитад хамрагдан 3 жилийн хугацаатай итгэмжлэгдсэн. Гэрчилгээний дугаар: MMC-42-2023 2025 оны жилийн эцсийн байдлаар СЭШХАА нь үндсэн, төрөлжсөн мэргэшлийн сургалтад боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо ISO21001 стандартыг нэвтрүүлэхийн тулд суурь стандарт болох ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны стандартыг хэрэгжүүлж ажиллаж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 90% 

	1.2 Үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлэх, нэмэгдүүлэх боловсруулж төрлийг	Шинэчлэн боловсруулж удирдах байгууллагаар батлуулсан сургалтын хөтөлбөрийн гарсан үр дүн дээд тоо,	УНТЭ нь дараах 11 чиглэлээр үндсэн мэргэшлийн сургалтыг зохион байгуулдаг бөгөөд хөтөлбөрийн шинэчлэл нь ЭМЯ, ЭМХТ хамтран 2021 оноос хийгдэж эхэлсэн. УНТЭ-т зохион байгуулагддаг төгсөлтийн дараах 11 чиглэлийн сургалт эрхлэгч төв тасгийн төлөөлөл ЭМЯ-наас гаргасан ажлын хэсэгт чиглэл бүрээр саналаа оруулан ажилласан. Төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийн шинэчлэл нь 2022-2024 бүрэн дуусаж, шинэ хөтөлбөрөөр үндсэн мэргэшлийн сургалтын үйл ажиллагаа явагдаж байна. 1. Дотрын анагаах судлал 2. Дүрс оношлогоо судлал 3. Мэдрэл судлал 4. Мэдээгүйжүүлэг судлал 5. Мэс засал судлал 6. Нүд судлал 7. Нүүр амны мэс засал судлал 8. Чих хамар хоолой судлал 9. Эрчимт эмчилгээ судлал 10. Эмнэлзүй эмгэг судлал 11. Яаралтай тусламж судлал   Тайлант хугацааны хэрэгжилт 100%
--	--	---	--

	1.3 Сургалт, эрдэм шинжилгээний төв байгуулах /эмнэл зүйн ур чадварын төв/	Эмнэлзүйн ур чадварын төв байгуулагдсан байх	УНТЭ-нь 2020 оны 1-р улиралд ашиглалтад орсон Сургалт эрдэм шинжилгээний төвд төгсөлтийн дараах танхимын сургалтын зохион байгуулж байгаа бөгөөд эмнэл зүйн ур чадварын хэсгийг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан шат дараатайгаар бий болгон сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. 2022 онд УНТЭ-ийн Сувилахуй эрхэлсэн албанаас нийт сувилагч нарын ажлын байран дахь мэргэжлийн ур чадварыг сайжруулах, гардан үйлдлийн сургалт зохион байгуулах “СУВИЛАХУЙН УР ЧАДВАРЫН ӨРӨӨ”-г өөрсдийн дотоод нөөцөд тулгуурлан хийж тус сургалтын өрөөнд сувилагч нар нийт 5 өртөөгөөр дадлага хийх боломжийг бүрдүүлсэн. 2020-2024 оны хугацаанд тус “ЭМНЭЛЗҮЙН УР ЧАДВАРЫН ӨРӨӨ”-г 800 гаруй суралцагчид суралцах үйл ажиллагаандаа ашигласан байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	1.4 Үндсэн мэргэшлийн сургалтын үнэлгээний аргыг нэвтрүүлж хэрэгжүүлэх	Цогц чадамжийн үнэлгээ, OSPE, OSCE, Case test, веб сайтад суурилсан аппликейшн	ЭМХТ-ийн үйл ажиллагааны зорилго, зорилтын хүрээнд өгөгдсөн чиглэлийн дагуу УНТЭ-ийн СЭШХАА нь үндсэн мэргэшлийн сургалтын үнэлгээнд Цогц чадамжийн үнэлгээг нэвтрүүлж сайжруулан, Science-fchm.mn вэб сайтыг хөгжүүлсэн. Төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаанд Мөн OSPE, OSCE, Case test-д суурилсан BOOST аппликейшныг нэвтрүүлсэн. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	1.5 Номын сангийн фондод сүүлийн үеийн шинэ гадаад ном, сурах бичгийн эзлэх хувийг 20%-иар өсгөнө.	Фондод нэмэгдсэн гадаад ном, сурах бичгийн төрөл тоо, ашиглалт	СЭШХАА-ны номын сангийн фондод анагаах ухааны сүүлийн үеийн цахим ном хэвлэлээр баяжуулах төлөвлөгөөний дагуу Z-LIBRARY цахим сайтаас анагаах ухааны салбарын 200 гаруй ширхэг цахим номыг үнэгүй татаж авч номын фондоо баяжуулсан. Тус номууд нь 2017 оноос хойш хэвлэгдсэн анагаах ухааны бүх салбар чиглэлээс бүрдсэн бөгөөд салбар тус бүрээр нь хавтас үүсгэн хадгалж байна.

			Мөн хэрэгцээтэй байгаа номуудыг уншигчдын и-мэйл хаяг руу илгээж цахим номын үйлчилгээг нэмэгдүүлж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
2.Төгсөлтийн өмнөх, төгсөлтийн дараах сургалтын чиглэлээр олон улс, үндэсний тэргүүлэх сургалт эрхлэгч байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх	2.1 Ази, Номхон далайн орнуудын сургалтын эмнэлгүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх	Санамж бичгийн тоо, хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлын тайлан, гарсан үр дүн	УНТЭ-ийн Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны алба нь эмнэлгийн гадаад харилцааг ази номхон далайн орнуудын сургалтын эмнэлгээр хязгаарлахгүйгээр өргөжүүлж байна. Үүнд АНУ, БНХАУ, Тайвань, Канад, БНТУ, БНСУ, ОХУ, БНЭУ зэрэг орны 30 гаруй эмнэлгүүдтэй эмч мэргэжилтнүүдээ сургах, шинэ технологи нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар харилцан ойлголцлын санамж бичиг үзэглэсэн. 2020-2024 онуудад УНТЭ нь жилд 20 гаруй сургалтын эмнэлэгтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд үүнээс байнга идэвхтэй үйл ажиллагаатай хамтарч байгаа 13 эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд байна. Мөн Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны алба төгсөлтийн өмнөх, төгсөлтийн дараах сургалтын чиглэлээр үндэсний тэргүүлэх сургалт эрхлэгч байгууллагуудтай туршлага солилцох болон хамтын үйл ажиллагаагаа үнэлж, дүгнэж ярилцах, цаашид сайжруулж ажиллах төлөвлөгөөндөө тусгах, хүсэл зорилгоо нэгтгэх зорилгоор 2022 оноос сургалт эрхлэгч байгууллагуудын удирдлага, холбогдох мэргэжилтэн, албадын дарга нарыг оролцуулсан нэгдсэн уулзалтыг жилд 1 удаа зохион байгуулдаг болсон. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ өндөр хөгжсөн олон улсын ялангуяа БНСУ, Япон, Тайвань, Турк улсын Эрүүл мэндийн салбарын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт, төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагаа, тогтолцоотой танилцан туршлага судалж эхэлсэн. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	2.2 Үндэсний хэмжээний сургалт, зөвлөгөөн зохион байгуулах	Жилд 4-5 удаа төрөлжсөн нарийн мэргэжлийн чиглэлээр сургалт зөвлөгөөн зохион байгуулах	Үндэсний хэмжээнд жил бүр УНТЭ-ийн Бөөрний төв, Гастроэнтерологийн төв, Урологи-Андрологийн төв, Дотоод шүүрэл судлал, диабетийн төв, Яаралтай тусламжийн тасаг, Эрчимт эмчилгээний тасаг, Мэдрэлийн эмнэлзүйн төв, Эрчимт эмчилгээний тасаг, Мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасгууд мэргэжлийн чиглэлээр олон улсын болон үндэсний хэмжээний сургалт, семинарыг тогтмол зохион байгуулж мэргэжлийн чиглэлийн эмч мэргэжилтнүүдээ чадавхижуулж байна.

			Мөн УНТЭ-ээс жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Эрдмийн чуулган”-д резидент эмчийн эрдэм шинжилгээний салбар хуралдааныг 2023 оноос нэмж зохион байгуулж, хэвшээд байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	2.3 Үндэсний эрүүл мэндийн сургалт эрхлэгч байгууллагуудын суралцагчдын дадлага сургалтын чанарыг сайжруулж, чадвартай эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх	Жилд сурган бэлтгэж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо, сургалтын чанарыг үнэлэх шалгуур үзүүлэлт батлагдсан байх, үнэлгээний дүн	УНТЭ нь сургалтын үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн сайдын болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын батлагдсан тушаал, шийдвэрийг мөрдөн ажиллаж сургалт эрхлэгч байгууллагын хүлээсэн үүргийн дагуу суралцагч нарын сургалтын чанарыг сайжруулах чиглэл, батлагдсан үнэлгээний арга зүйг ашиглан хэвшсэн. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
3.Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чанарыг сайжруулж, судлаачийн нэмэгдүүлэн, үнэлгээ, урамшууллын системийг сайжруулах	3.1 Судалгааны тэргүүлэх чиглэлээ тодорхойлж судалгааны баг, орон тооны бус судалгааны хүрээлэн (институт) байгуулах	Судалгааны баг, орон тооны бус судалгааны хүрээлэн (институт) байгуулагдсан байх, үйл ажиллагааны тайлан, гарсан үр дүн	УНТЭ-т тайлант хугацаанд судалгааны баг, орон тооны бус судалгааны хүрээлэн (институт) байгуулаагүй боловч орон тооны бус “Эрдмийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг жил бүр шинэчлэн, сайжруулж “Эрдэмтдийн зөвлөл” нэртэйгээр, үйл ажиллагаагаа зохион байгуулж, хуралдах болон эрдэм шинжилгээний бүтээл, кейс тохиолдол хянах хэлэлцүүлэх бүрт цалин олгох заалтыг тусгаж, хэрэгжүүлж ажиллаж байна. /УНТЭ-ийн 2023.11.06-ны өдрийн А/295 тоот тушаал/ УНТЭ-ийн Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны алба нь жил бүр судлаачийн тоог нэмэгдүүлэн, үнэлгээ, урамшууллын системийг сайжруулах зорилгоор олон улсын IF өндөртэй болон чансаа өндөр сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн судлаач, эрдэмтдэд эмнэлгийн ерөнхий захирлын нэрэмжит шагналыг гардуулдаг болсон төдийгүй судлаач эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг судалгаа, шинжилгээний ажи хийх, магистр докторын зэрэг хамгаалж буй ажилтны улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал, жилийн эцсийн тасаг, төв, нэгжийн тайлангийн үнэлгээнд өндөр онооны үнэлгээгээр дүгнэж, харгалдзаг болсон. Мөн докторын зэрэг хамгаалсан эмч ажилтнуудад нэг удаагийн мөнгөн тэтгэмжээр урамшуулах заалтыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлэн ажиллаж байгаа төдийгүй хөдөлмөрийн дотоод журмын шинэчлэх саналд магистрын зэргээ хамгаалсан ажилтнуудад 1 удаагийн тэтгэмж олгох саналыг оруулаад байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%

	3.2 Судлаачдын судалгааны үр дүнг олны хүртээл болгож олон улсын эрдмийн чуулган, хуралд хэлэлцүүлэх	Олон улсын эрдмийн чуулган, хуралд судалгааны үр дүнг хэлэлцүүлсэн судлаачдийн тоо	УНТЭ-ийн захиргаа, СЭШХАА-аас хамтран олон улсын эрдмийн чуулганд өөрийн хийсэн судалгааны үр дүнг танилцуулж буй судлаач эмч нараа тогтмол дэмжиж хамтран ажилладаг бөгөөд сүүлийн жилүүдэд ЭШСТ, ДШСДТ, БТ, ЦЭСЧШСТ, ГЭТ, ЧХХСМЗТ, УАТ, БШГМЗТ, МЭТ зэрэг эмнэлзүйн төв тасгийн эрдэмтэн судлаачид ХБНГУ, БНТУ, БНСУ, АНУ зэрэг орнуудад мэргэжлийн чиглэлээр зохион байгуулагдсан олон улсын эрдэм шинжилгээний хурлуудад оролцож судалгааны үр дүнгээ танилцуулах тоо жил бүр өссөөр байна. 2020-2024 оны байдлаар тус судлаачдын тоо 76 байна. Судлаачдынхаа бүтээлийг олны хүртээл болгож, хэрэглээний эргэлтэд оруулах зорилгоор Байгууллагын гадаад сайтын “Сургалт, судалгаа” цонхонд 1999 оноос 2024 он хүртэлх Эрдмийн бичиг, эмхэтгэлийг түүхчилж байршуулсан бөгөөд ингэснээр байгууллагын судалгааны нэгдсэн санг үүсгэсэн гэж үзэж болно. Үндэсний судалгааны нэгдсэн санд байгууллагын хэрэгжүүлсэн төслийн тайлан болон 2020 оноос зохион байгуулдаг болсон “Ховор тохиолдлын үндэсний чуулган”-ы илтгэл, кейс тохиолдлын эмхэтгэлийг байршуулсан бөгөөд энэ нь “онцлох судалгаа”-ны байнгын хандалтын тэмдэглэгээтэйгээр олон түмний хүртээл болоод байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	3.3 Идэвхтэй судлаачдын тоог нэмэгдүүлэн, судлаачид олгох тэтгэлгийн бодлого хэрэгжүүлэх хөтөлбөр	Бодлогын бичиг баримтыг боловсруулан батлуулж мөрдөн ажиллаж хэвшсэн байх	УНТЭ-ийн ерөнхий захирлын 2023 оны А/295 тоот тушаалаар “Эрдмийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталсан бөгөөд тус зөвлөлийн журмыг жил бүр шинэчлэн, сайжруулж “Эрдэмтдийн зөвлөл” нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тус журмын дагуу эрдэмтдийн зөвлөл хуралдах бүрт, эрдэм шинжилгээний бүтээл, кейс тохиолдол хянах хэлэлцүүлэх бүрт цалин олгох заалтыг тусгаж, хэрэгжүүлж ажиллаж байна. УНТЭ-ийн Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны алба нь жил бүр судлаачийн тоог нэмэгдүүлэн, үнэлгээ, урамшууллын системийг сайжруулах зорилгоор олон улсын IF өндөртэй болон чансаа өндөр сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн судлаач, эрдэмтдэд эмнэлгийн ерөнхий захирлын нэрэмжит шагналыг гардуулдаг болсон төдийгүй судлаач эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг судалгаа, шинжилгээний ажи хийх, магистр докторын зэрэг хамгаалж буй ажилтны улирлын үр дүнгийн мөнгөн

			урамшуулал, жилийн эцсийн тасаг, төв, нэгжийн тайлангийн үнэлгээнд өндөр онооны үнэлгээгээр дүгнэж, харгалдзаг болсон. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
4.Сургалт, эрдэм шинжилгээний ажлыг дэмжсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	4.1 Байгууллагын эрдэм шинжилгээ, судалгааны төсөл сонгон шалгаруулж санхүүжүүлэх	Төсөл сонгон шалгаруулах журам батлагдсан байх, журмын дагуу сонгон шалгаруулж тэтгэлэг олгосон төслийн тоо, гаргасан үр дүн	УНТЭ нь тайлант хугацаанд байгууллагын эрдэм шинжилгээ, судалгааны төсөл сонгон шалгаруулах журмыг боловсруулан батлуулаагүй боловч 2020-2024 онуудад ЭМЯ-ны болон Шинжлэх ухаан технологийн сан, Жайка төсөл, Койкагийн төслийн сонгон шалгаруулалтад байгууллагаас дэмжиж илгээх төсөл хөтөлбөрийг Эрдэмтдийн зөвлөлийн хурлаар тухай бүр хэлэлцүүлэн шалгаруулж, бэлтгэлийг ханган дэмжлэг үзүүлдэг. Төсөл сонгон шалгаруулах журмыг төрийн захиргааны төв байгууллага боловсруулан батлуулж нийт эрүүл мэндийн байгууллагууд даган мөрдөж ажиллаж байна. Тайлант хугацаанд дэмжиж илгээсэн төсөлт ажлуудаас сонгон шалгаруулалтад тэнцсэн төсөл байхгүй байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	4.2 Магистрант, докторантурын олон улсын солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх	Олон улсын солилцооны хөтөлбөрт хамрагдсан магистр докторын тоо	Тайлант хугацаанд ЕМЗТ-ийн их эмч Т.Мөнхболд АНУ-д, ГЭТ-ийн их эмч н.Аюуш Япон улсад докторын сургалтад хамрагдсан. ХҮСҮСТ-ийн их эмч н.Түвшинжаргал БНСУ-д суралцах хугацаанд ажлын байрыг хадгалж байна. 2022-2023 онуудад зүрхний төвийн их эмч Г.Ананд хэм алдагдлын чиглэлээр БНСУ-д суралцаж ирсэн бөгөөд байгууллагын зүгээс 30,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тайлант хугацааны хэрэгжилт 100%

ТЭРГҮҮЛЭХ СТРАТЕГИ 5. ЭРСДЭЛГҮЙ, ЭЭЛТЭЙ ОРЧИН, ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ТАСРАЛТГҮЙ САЙЖРУУЛАХ

ЗОРИЛГО: Олон улсын магадлан итгэмжлэлийн стандартуудыг хангасан ээлтэй, эрсдэлгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний орчинг бүрдүүлж, чанарын удирдлагын тогтолцооны хамрах хүрээг өргөжүүлэн, өрсөлдөх чадвараа бэхжүүлэхэд оршино.

ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	ЗОРИЛТ	ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ	ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН, ҮНЭЛГЭЭ
1. Олон улсын магадлан итгэмжлэлийн хөтөлбөрт хамрагдах ажлыг эхлүүлэх	1.1 JCI олон улсын магадлан итгэмжлэлийн гишүүнчлэлд бүртгүүлэх	Гишүүнчлэлд бүртгүүлсэн тухай албан бичиг, зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын тайлан	Тайлант онуудад буюу 2020-2024 онд УНТЭ нь JCI олон улсын магадлан итгэмжлэлийн гишүүнчлэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулаагүй боловч Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх чиглэлээр зөвлөх үйлчилгээний компани болох “УАЙ ЭС КОНСАЛТИНГ” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажилласан бөгөөд 2023 оны 12 дугаар сард Мон Майнинг Сертификейшн ХХК-тай баталгаажуулалтын үйлчилгээний гэрээ байгуулан 12 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд баталгаажилтын аудитад хамрагдан 3 жилийн хугацаатай итгэмжлэгдсэн. Гэрчилгээний дугаар: MMC-42-2023 Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2015 суурь стандартыг нэвтрүүлэх чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулсан. - Эмнэлгийн хэмжээнд стандартын сургалтыг жилийн турш хуваарь гарган зохион байгуулсан. - ЧМТ MNS ISO 9001:2015 стандартын дотоод аудитын шалгалт хийх эрх бүхий 32 эмч, эмнэлгийн



			мэргэжилтнүүдийг бэлтгэж, 2023 онд 22 нэгжид, 2024 онд 28 нэгжид хяналт үнэлгээ хийсэн. 3. Нийт 41 алба, төв, тасаг нэгжийн 634 чиг үүрэг, процесс зурагдаж эмнэлгийн захирлын 2023 оны А/137 тоот “Алба, төв, тасаг, нэгжийн чиг үүрэг, үйл явцын зураглалыг батлах тухай” тушаалаар батлагдсан. 4. ЧМТ MNS ISO 9001:2015 стандарт шаардлагын дагуу 14 журмыг шинэчлэн боловсруулж батлуулж өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 70%
	1.2 JCI олон улсын магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг хангах гарааны үнэлгээг хийх	Гарааны үнэлгээг хийлгэсэн тухай тайлан, зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын тайлан	2024 оны жилийн эцсийн байдлаар JCI олон улсын магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг хангах гарааны үнэлгээнд хамрагдах талаар зохион байгуулсан ажил хийгдээгүй тул хэрэгжилтийг тооцох боломжгүй. Шинэчлэн батлах стратеги төлөвлөгөөнд тусгах.
	1.3 JCI олон улсын магадлан итгэмжлэлийн хөтөлбөрт хамрагдаж, туршлага судлах, баталгаажилтад бэлтгэх	Хөтөлбөрт хамрагдсан мэргэжилтнүүдийн тоо, туршлага судлах чиглэлээр гаргасан тушаал шийдвэр, томилогдон ажилласан ажилтны тоо, баталгаажилтанд орох үнэлгээний болон хийсэн ажлын тайлан	2024 оны жилийн эцсийн байдлаар JCI олон улсын магадлан итгэмжлэлийн хөтөлбөрт хамрагдаж, туршлага судлах, баталгаажилтад бэлтгэх талаар зохион байгуулсан ажил хийгдээгүй тул хэрэгжилтийг тооцох боломжгүй. Шинэчлэн батлах стратеги төлөвлөгөөнд тусгах.
2.Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, үйлчилгээний ээлтэй орчинг бүрдүүлэх	2.1 Үйлчилгээний менежментийн тасралтгүй сайжруулалтыг хийх	Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны хувь нэмэгдэх, зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын тайлан	ЭМТҮЧАБА-аас ЭМС-ын 2022 оны А/346 тоот “Журам шинэчлэн батлах” тухай тушаалын дагуу хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг эрүүл мэндийн байгууллагууд sudalгаа 1313.mn холбоосоор нэвтэрч орон, өөрийн байгууллагад хамаарах QR код үүсгэн судалгааг авч байна. Шинээр өөрийн байгууллагын үйлчлүүлэгчийг тогтмол судлах, үйлчлүүлэгчийн хэрэгцээг тогтмол тодорхойлох чиглэлээр тодорхой ажил зохион байгуулаагүй боловч иргэдэд ээлтэй тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх чиглэлээр 11.00 ажлын хэсгийг байгуулан тусламж үйлчилгээний зохион байгуулалтыг сайжруулах, засвар хийж үйлчлүүлэгчийн үйлчилгээ авах орчин нөхцөлийг тав тухтайгаар бүрдүүлэх, үйлчилгээг цахимжуулах, ил тод

			нээлттэй болгох, ажилтнуудын ажлын цаг ашиглалтыг сайжруулах, хаяг хаягжилтийг нэмэгдүүлэх, гэрэлтүүлгийг сайжруулах, чанарын хяналт зохион байгуулах, угтах, чиглүүлэх үйлчилгээг үр дүнтэй, болгох ажлуудыг тасралтгүй зохион байгуулж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 70%
2.2 Эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын тасгийн барилга, байгууламжийн өргөтгөл хийх	Барилгын төсөв хөрөнгийн асуудал шийдвэрлэгдэж, батлагдсан зураг төсвийн дагуу барилга баригдсан байх	Тус арга хэмжээг МУ-ын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. Мөн Засгийн Газрын 2023 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн хуралдаанаар 2024 оны төсөвт “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын төсөв”-ийг тусгахаар шийдвэр гарч Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилга /А блок/, Авто зогсоолын барилга /Б блок/-г барих тендерийг зарлаж, гүйцэтгэгч компаниар Магнус сентурион констракшн ХХК шалгарч, Эрүүл мэндийн яам болон Магнус сентурион констракшн ХХК нь 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдөр УТ2402002274 ХО/99 дугаартай гэрээ байгуулж барилгын ажил эхэлсэн. Тайлант хугацааны хэрэгжилт 90%	XVIII.1.71 ЭС, ЭД, ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТӨВ ЛУААНБААТАР, СҮХБААТАР ДҮҮРЭГ-ЫН АЖЛЫН ГЭРЭЭ Дугаар: УТ2402002274 ХО/99 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдөр Улаанбаатар хот Нэг талаас: Эрүүл мэндийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас: “Магнуссентурион Констракшн” ХХК болон “Сентурио” ХХК-ийн түншлэл (цаашид “гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав. ЗАХИЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛГЧ: ТӨРИЙН НАРИЙН БИЧИГЛЭН ДАРГА Д.СЧИРБАТ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛГЧ: “МАГНУССЕНТУРИОН КОНСТРАКШН ХХК”-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ В.ТАНТУЛГА САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН ДАРГА Рекстэй дугаар: 5934273 Улсын бүртгэлийн дугаар: 9011531141 Илүүвсэн
2.3 Эмнэлгийн орчны бүрэн шинэчлэлт, тохижилт	Орчны шинэчлэл, тохижилтийн чиглэлээр жил бүр хийсэн ажлын тайлан, мөнгөн дүн, хамрагдсан болон хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт	Тайлант хугацаанд буюу 2020-2024 онд Зүрхний төв, Мэдрэлийн эмнэлзүйн төв, Эрүү нүүрний мэс заслын тасаг, Ерөнхий мэс заслын тасаг, Урологи-Андрологийн төв, Гал тогооны хэсэг, Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасаг, Чих хамар хоолой судлал, мэс заслын тасаг, Амбулаторийн хэсэг, Яаралтай тусламжийн тасаг, А блокын 2 давхрын коридор зэрэг төв, тасаг, нэгжүүдэд засвар хийж орчны бүрэн шинэчлэл тохижилт хийгдсэн. Тайлант хугацааны хэрэгжилт 100%	

	2.4 Дотор, мэс заслын тасгийн зохион байгуулалтын нэгдсэн системд шилжих	Хэвтэл гаралтын нэгдсэн тогтолцоо нэвтэрсэн байх	Хэвтэлт гаралтын нэгдсэн тогтолцоо дотрын хэсэгт нэвтэрсэн. Эмнэлгийн захирлын 2020 оны А/233 тоот “Улсын нэгдүгээр төв эмнэлэгт хэвтэлт, гаргалтын нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэх тухай” тушаалаар журам батлагдсан. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
3.Цахим технологи, мэдээллийн аюулгүй байдлыг бэхжүүлэх	3.1 Серверийн үйлдлийн системүүдийг өргөжүүлэн баталгаажуулах	Зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын тайлан, хамтран ажиллах гэрээ, хөрөнгө оруулалтын мөнгөн дүн	Тайлант хугацаанд эмнэлгийн мэдээлэл технологийн албанаас дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 1. Эмнэлгийн хэмжээнд шинээр суурилуулсан 1 ш сервер компьютерийн үйлдлийн системийг албан ёсны лицензтэй болгосон. 2. Эмнэлгийн Windows-7 үйлдлийн систем бүхий компьютеруудын үйлдлийн системийг шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. 3. Сүлжээний гарц дээрх ГАЛТ ХАНА төхөөрөмжийг шинэчлэх худалдан авалтыг зохион байгуулж Тагнуулын ерөнхий газраар шалгуулж хүлээн аваад суурилуулсан. 4. 2024 онд серверийн өрөөний UPS буюу тог баригчийн 6 ширхэг батерейг худалдан авч сольсоноор сервер болон сүлжээний аюулгүй байдлыг бүрэн хангасан. 5. Эмнэлгийн сүлжээг нийт 38 дэд сүлжээнд хуваан төв тасгуудын сүлжээний ачааллыг багасгасан. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	3.2 “Ehealth” программд эмч нарын гар утсанд эмч дуудах автомат дуут дохиоллын системийг нэвтрүүлэх	Дохиоллын систем эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрэх	“Ehealth” програмд эмч дуудах модуль хийгдэж яаралтай тусламжийн тасагт дуудлагаар ирж буй эмч нар үзлэгийн тэмдэглэлийг яаралтай тусламжийн хуудсанд тэмдэглэн хэвшсэн. Тайлант хугацааны хэрэгжилт 100%.
	3.3 Үйлчлүүлэгчийн өвчний картыг цахимжуулах	Амбулаторийн үйлчлүүлэгчийн өвчний карт цахимжсан байх	Байгууллагын мэдээллийн санд 2006 оноос хойшхи амбулаториор үйлчлүүлэгчийн түүх, 2011 оноос хойшхи лабораторийн шинжилгээний хариу, 2017 оноос хойшхи хэвтэн эмчлүүлэгчийн түүхийн мэдээллийг хадгалж байна. Мөн эдгээр мэдээллийг үйлчлүүлэгч e-Mongolia аппликейшн ашиглан авах боломжтой болсон. Тайлант хугацааны хэрэгжилт 100%.

4. Ажилтнуудын нийгмийн баталгаа, ажлын орчинг сайжруулах	4.1 Brand book-тэй болох	Байгууллагын шинэ брэнд бүүкийг боловсруулан батлуулж, хэрэглээнд нэвтрүүлсэн байх	Байгууллагын брэндбүүк шинэчлэх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийсэн. Лого болон хаягжилт, бичиг хэрэг сошиал орчинд ашиглах постер зэрэг нь бүрэн шинэчлэгдсэн. Тайлант хугацааны хэрэгжилт 100%.
	4.2 Ур чадварын тогтолцоонд бүтээмжийг ажигтнуудын 50%-80%-иар нэмэгдүүлэх	Батлагдсан шалгуур үзүүлэлт, хэрэглээнд нэвтэрсэн программ хангамж, санхүүгийн тайлан, холбогдох тушаал шийдвэр	Монгол улсын Засгийн газрын 2019.01.09-ний өдрийн 05 дугаар тогтоолыг үндэслэн Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын 2020.04.02-ны өдрийн А/138 тоот тушаалаар "УНТЭ-ийн ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг дүгнэх, улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журам", 2022.04.26-ны өдрийн Б/178 тоот "Эрүүл мэндийн ажилтанд ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох тухай" тушаалыг тус тус мөрдөн ажиллаж байна. Ерөнхий захирлын 2022.09.07-ны өдрийн А/270 тоот "Гэрээ байгуулах тухай" тушаалын дагуу "Эрүүл амьдралыг иргэн бүрт" ТББ-тай УНТЭ119/22 дугаар бүхий гэрээг байгуулан ажиллаж байна. Зарцуулах төсөв 19,9 сая төгрөг ба эмнэлгийн ажилчдын бүтээмж, үр дүнд суурилсан гүйцэтгэлийг үнэлэх журам, шалгуур үзүүлэлтийг боловсруулан хүлээлгэж өгөх ажлын хүрээнд байгууллагын үйл ажиллагааны үзүүлэлтэд дүн шинжилгээ хийсэн. КРІ буюу гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт боловсруулах үйл ажиллагаатай холбоотой ЗХНА-наас ажилтнуудын үнэ цэнийн судалгааг авсан. 2020 онд нийт ажилчдад бүтээмжийн урамшуулал 10%-ийг үндсэн цалингаас тооцож олгож эхэлсэн ба 2020 онд бүтээмжийн урамшуулалыг 30% болгож тус урамшуулалыг үндсэн цалинг өсгөх замаар шилжүүлэн үндсэн цалинг 30%-иар нэмэгдүүлсэн. 2023 онд хоол унааны мөнгийг 2500 төгрөгөөр, 2024 оны 1-р сарын 01-нээс 2500 төгрөгөөр тус тус нэмж хоногийн 10,000 төгрөг болгосон. 2024 оны 09-р сарын 01-нээс нийт сувилагч нарын үндсэн цалинг 27%-иар нэмэгдүүлсэн байна. Гүйцэтгэлийн санхүүжилтийн үр дүнд нийт ажилчиддаа 13 дахь сарын цалин 2022 онд 950,0 сая төгрөг,

			2023 онд 3,5 тэрбум төгрөг, 33 ажилчинд орон сууцны урьдчилгаа тус бүр 30,0 сая төгрөг нийт 900,0 сая төгрөгийг, 2024 онд 1,4 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна. Засгийн газрын 5-р тогтоолын дагуу улирал тутам олгодог 60%-ийн үр дүн урамшууллыг журманд заасан хугацаанд эхний цалин дээр олгож хэвшүүлсэн байна. Үүнд: ➤ 2020 онд 763,2 сая төгрөг ➤ 2021 онд 892,6 сая төгрөг ➤ 2022 онд 1,1 тэрбум төгрөг ➤ 2023 онд 1,4 тэрбум төгрөг ➤ 2024 онд 1,5 тэрбум төгрөг тус тус олгосон байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	4.3 Бүх ажилтнуудыг 1-2 ээлжийн ажлын хувцас хэрэглэлээр хангах	Худалдан авалтын тайлан, ханган нийлүүлсэн хувцас хэрэглэлийн тоон үзүүлэлт	2020, 2021, 2022, 2023, 2024 онуудад эмнэлгийн нийт ажилтнуудыг стандартын шаардлагад нийцсэн ажлын дүрэмт хувцас болох, халад, хослол, гутал зэргээр бүрэн хангасан. Жилдээ эмч халад 200 ширхэг, хагалгааны филтерийн хувцас 300 ширхэг, сувилагч өмд, цамц 200 ширхэг нийлүүлэгдэж байсан. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	4.4 Байгууллагын ажилтнуудын эрүүл мэндийг хариуцсан эмч, сэтгэл судлаачийн ажлын байрыг бий болгож, ажиллуулах	Ажилтнуудын эрүүл мэндийг хариуцсан эмч, сэтгэл судлаач бүрэн орон тоогоор ажилладаг болсон байх, холбогдох тушаал шийдвэр	Тайлант хугацаанд байгууллагын ерөнхий захирлын 2020.03.31-ний өдрийн Б/171 тоот тушаалаар Сэтгэцийн эмгэг судлаач, сэтгэл заслын эмчийг ажилд авсан. Ерөнхий захирлын 2020.04.27 өдрийн Б/218 тоот тушаалаар А.Оюунжаргалыг ажилтнуудын эмчийн ажлыг хослон гүйцэтгүүлэхээр томилсон. УНТЭ-ийн Нийгмийн эрүүл мэндийн албаны сэтгэцийн эмгэг судлаач, сэтгэл заслын эмч А.Оюунжаргал нь жилдээ 100 орчим ажилтнуудад сэтгэлзүйн зөвлөгөө өгч, эмчилгээнд хамруулж эмчилж байна. Их эмч А.Оюунжаргал нь сэтгэл заслын эмчилгээндээ урлагийн сэтгэл заслын эмчилгээний дараах аргуудыг нэвтрүүлж эхлээд байна. 1) “Хүн байшин мод” одоогийн сэтгэлзүйн байдал, сэтгэлзүйн гэмтлийг илрүүлэх зургийн сорил; 2) Проектив сэтгэл заслын зурган картууд

			3) Персона /Хувь хүний сэтгэл зүйн байдал, тулгамдаж буй асуудал, харилцааны зөрчлийг илрүүлэх, сэтгэл засах/ 4) Персонита /Хувь хүний сэтгэл зүйн байдал, бага насны сэтгэл зүйн гэмтлийг илрүүлэх, сэтгэл засах/ 5) Инук /Бага насны сэтгэл зүйн гэмтлийг илрүүлэх, сэтгэл засах/ 6) Oh card /Хувь хүний сэтгэл зүйн байдал, бага насны сэтгэл зүйн гэмтлийг илрүүлэх, сэтгэл засах/ 7) Амьдрахын тулд уучил /Уй гашуутай ажиллах, сэтгэл засах/ 8) EQ- /хүүхдийн сэтгэл хөдлөлтэй ажиллах/ картууд зэрэг шинэлэг аргуудыг ашиглаж байна. Мөн ажилтнуудын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр шинэ сувилагч нарт “Ажлын байранд дасан зохицохуй” “Стресс менежмент” сэдэвт сургалтыг, мэдрэл сэтгэхүйн хувьд өндөр ачаалал авч ажилладаг Эрчимт эмчилгээний тасаг, Яаралтай тусламжийн тасгуудад “Ажлын байран дээрхи эерэг уур амьсгал” сэдвээр проектив зурган картын аргаар бүлгийн сэтгэл засал эмчилгээг жилд 1-2 удаа, нийт ажилчдад “Сэтгэцийн эрүүл мэнд ба сэтгэл зүйн сайн сайхан байдал” “Стресс ба таргалалт” сэдэвт сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	4.5 Өндөр эрсдэлтэй ажлын байранд тавигдах шаардлагын дагуу ажилтнуудыг хамгаалах хувцас хэрэгслэлээр бүрэн хангах	Худалдан авалтын тайлан, ханган нийлүүлсэн хувцас хэрэглэлийн тоон үзүүлэлт	2020-2024 онуудад ЭХААҮХТА-наас өндөр эрсдэлтэй ажлын байранд ажилладаг эмнэлгийн нийт ажилтнууд буюу хог хаягдлын ажилтан, ИБА-ны слесариуд, цахилгааны инженер, цахилгаанчин, рентген туяатай ажилладаг ажилтнууд, хүчилтөрөгчийн инженер, техникч нар, гадаа талбайн ажилтнуудад стандартын шаардлагад нийцсэн ажлын дүрэмт хувцсаар төсөвт тусгагдсаны дагуу ханган ажилласан. Тайлант хугацааны хэрэгжилт 90%

	4.6 “Ажилтнуудын амрах өрөө” төслийг хэрэгжүүлэх	Ажилтнууд амрах өрөөтэй болсон байх, хөрөнгө оруулалтын мөнгөн дүн	Тайлант хугацаанд эмнэлзүйн төв тасгуудад “Ажилтнуудын амрах өрөө”-г бүрэн тохижуулж өгсөн. Дэмжих үйлчилгээний албадуудаас эхний ээлжинд ЭХААҮХТА-ны үйлчилгээний ажилтнуудад амрах өрөөг тохижуулж өгсөн бөгөөд 2024 оны байдлаар дэмжих үйлчилгээний албадууд бүгд амрах өрөөтэй болсон. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	4.7 Амьдралын баталгаажих түвшин доогуур, олон жил үр бүтээлтэй ажилласан ажилтнуудад эд материалын болон гэр, хашааны дэмжлэг үзүүлэх	Зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын тайлан, дэмжлэгт хамрагдсан ажилтнуудын тоо	2020 онд МУ-ын ЗГ, ЭМЯ-наас хамтран хэрэгжүүлсэн “Түрээслээд өмчлөх орон сууцны хөтөлбөр”-т 45 ажилтныг хамруулсан. 2022 онд эрүүл мэндийн ажилтныг дэмжих сарын аяны хүрээнд орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлж 30 ажилтанд тус бүр 30,0 сая төгрөг нийт 900,0 сая төгрөг олгохоор шийдвэрлэж 30 ажилтныг орон сууцтай болгосон. Гэр бүл-3, Сувилагч-23. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	4.8 Шалгуур хангасан ажилтнуудыг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах	Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан ажилтнуудын тоо	2020 онд МУ-ын ЗГ, ЭМЯ-наас хамтран хэрэгжүүлсэн “Түрээслээд өмчлөх орон сууцны хөтөлбөр”-т 45 ажилтныг хамруулсан. 2022 онд эрүүл мэндийн ажилтныг дэмжих сарын аяны хүрээнд орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлж 30 ажилтанд тус бүр 30,0 сая төгрөг нийт 900,0 сая төгрөг олгохоор шийдвэрлэж 30 ажилтныг орон сууцтай болгосон. Гэр бүл-3, Сувилагч-23. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
5. “Эко эмнэлэг” төсөл хэрэгжүүлэх	5.1 Эмнэлгийн гадаад орчинг зүлэгжүүлэх, цэцэгжүүлэх	Хийсэн ажлын тайлан, зүлэгжүүлж тохижуулсан талбай м.кв-аар	2020-2021 онд Нийслэлийн захирагчийн ажлын албаны гүйцэтгэгч байгууллага болох “ЖИ ПИ ЭКСПРЭСС ФИНАНС” ХХК-тай хамтран УНТЭ нь А блокын урд талбай буюу нийтийн эзэмшлийн том талбайг бүрэн зүлэгжүүлж тохижуулсан. 2023-2024 онуудад Эмнэлгийн хэрэгсэл, аж ахуй, үйлчилгээ, хангамж түгээлтийн албанаас Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих сан, Люксландшафт ХХК, Улсын нэгдүгээр төв эмнэлэгтэй гурвалсан гэрээ байгуулан эмнэлгийн гадна талбайн тохижилтын ажлыг хийсэн. Үүнд 1. Зүлэгжүүлэлтийг нийт 925м ² талбайд хийж ногоон орчин бүрдүүлсэн. 2. Моджуулах зорилгоор бүйлс 20ш, голтбор 25ш, агч мод 4ш, үхрийн нүд 6ш, тэхийн шээг 10ш, хус 3ш,

			гацуур 10ш, өрөл 8ш, монос 4ш нийт 90 ширхэг мод тарьж ургуулсан. УНТЭ-ийн Эмнэлгийн хэрэгсэл, аж ахуй, үйлчилгээ, хангамж түгээлтийн алба нь цаашид эмнэлгийн гадаад орчинг зүлэгжүүлэх, цэцэгжүүлэх ажлыг мэргэжлийн түвшинд хийж сурахын тулд ногоон байгууламжын арчилгааны сургалтыг Люксландшафт ХХК-аас 2 удаа авсан бөгөөд гадна талбайн ажилчдын багаж хэрэгслийг шинэчилсэн. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	5.2 Хог хаягдлын менежментийг сайжруулж “эко” хэрэглээнд шилжих	Зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын тайлан, гарсан үр дүн	2024 онд эмнэлгийн эм зүйн албанаас “Байгальд хайртай байгууллага” уриатай, нийт эрүүл мэндийн байгууллагуудын хүрээнд анхдагч болох эмийн хог хаягдлыг ангилж хаях аяныг өрнүүлж, төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Аяны зорилго нь ирээдүй хойч үеэ эрүүл аюулгүй орчинд амьдруулах, эмийн хаягдлаас хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг бууруулах, эмийн хог хаягдлыг зориулалтын дагуу зөв ангилж устгах юм. Тус аяны хүрээнд УНТЭ -ийн Ерөнхий захирлын 2024 оны 10 сарын 04-өдөр А/313 тоот “Байгальд ээлтэй байгууллага” аян зохион байгуулах тушаал, ажлын хэсэг, хийх ажлын төлөвлөгөө, шаардагдах төсвийг хийн батлуулж 2024.11.18-ны өдөр аяны нээлтийг хийсэн. Тайлант хугацааны хэрэгжилт 50%
	5.3 Дугуйны зогсоолыг сайжруулан өргөжүүлэх	Зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын тайлан, гарсан үр дүн	Эмнэлгийн гадна талын урд талын зогсоолд дугуйн зогсоол барьсан. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
6. Чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, хамрах хүрээг өргөжүүлэх	6.1 Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг хэвтүүлэн эмчлэх тасаг төвүүдэд нэвтрүүлэн нутагшуулах	Зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын тайлан, магадлан итгэмжлэлийн гэрчилгээ	УНТЭ нь 2023 онд Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2015 стандартыг эмнэлгийн хэмжээнд хэвтүүлэн эмчлэх төв тасгуудыг хамруулан нэвтрүүлэх чиглэлээр зөвлөх үйлчилгээний компани болох “УАЙ ЭС КОНСАЛТИНГ” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажилласан бөгөөд 2023 оны 12 дугаар сард Мон Майнинг Сертификейшн ХХК-тай баталгаажуулалтын үйлчилгээний гэрээ байгуулан 12 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд баталгаажилтын аудитад хамрагдан 3 жилийн хугацаатай итгэмжлэгдсэн.

			Гэрчилгээний дугаар: MMC-42-2023 Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2015 суурь стандартыг нэвтрүүлэх чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулсан. 1. Эмнэлгийн хэмжээнд стандартын сургалтыг жилийн турш хуваарь гарган зохион байгуулсан. 2. ЧМТ MNS ISO 9001:2015 стандартын дотоод аудитын шалгалт хийх эрх бүхий 32 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг бэлтгэж, 2023 онд 22 нэгжид, 2024 онд 28 нэгжид хяналт үнэлгээ хийсэн. 3. Нийт 41 алба, төв, тасаг нэгжийн 634 чиг үүрэг, процесс зурагдаж эмнэлгийн захирлын 2023 оны A/137 тоот “Алба, төв, тасаг, нэгжийн чиг үүрэг, үйл явцын зураглалыг батлах тухай” тушаалаар батлагдсан. 4. ЧМТ MNS ISO 9001:2015 стандарт шаардлагын дагуу 14 журмыг шинэчлэн боловсруулж батлуулж өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	6.2 Эрсдэлийн менежментийг нэвтрүүлэн, эрсдэлийн цахим сантай болох	Менежментийг нэвтрүүлэх чиглэлээр хийсэн ажлын тайлан, төлөвлөгөө, үүсгэсэн цахим сангийн мэдээлэл, холбогдох дүрэм журам	УНТЭ-ийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албанд эрсдэл хариуцсан менежер бүрэн орон тоогоор ажиллаж байна. Эрсдлийн бүртгэлтэй, эрсдлийн баг болон ажиллах журмыг 2022 онд A/341 тоот эмнэлгийн ерөнхий захирлын тушаалаар батлуулсан. Жил бүрийн хэрэгжилтийн тайлан гаргадаг. 2024 оны байдлаар MNS ISO 9001:2015 “Чанарын менежментийн тогтолцоо” стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор ЭМТҮЧАБА-ны цахим хаягт нийт 13 асуумж бүхий маягтаар QR код үүсгэн 68 эрсдэлийг бүртгэн цахимаар эрсдэлийн нэгдсэн сан үүсгэн ажиллаж байна. Мөн ЭМС-ын 2024 оны A/112 тоот тушаалын дагуу HTTPS://EBURTGEL.HDC.GOV.MN цахим хаягаар эмнэлзүйн болон эмнэлзүйн бус 68 эрсдэлийг ЭМХТ-д бүртгэн сан үүсгэн ажиллаж байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%

	6.3 Чанарын удирдлагын тогтолцооны стандарт шаардлагын дагуу дотоод хяналт, үнэлгээний системийг хэрэгжүүлж хэвшүүлэх	Бэлтгэгдсэн дотоод аудиторын тоо, төлөвлөгөө, тайлан, гарсан үр дүн	2023 онд УНТЭ-ийн ЗАА болон ЭМТҮЧАБА-ууд хамтран Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2015 стандартын нэвтрүүлэх, стандартын талаарх ажилтны ойлголт болон шаардлагатай баримт бичгийн бүрдүүлэлтийн байдалд үнэлгээ хийх зорилгоор Ерөнхий захирлаар байгууллагын хэмжээнд стандартын аудит хийх хуваарийн төлөвлөгөөг баталж гаргасан. Нийт эмнэлгийн хэмжээнд 32 стандартын аудит бэлтгэж, сертификат гардуулсан. Эмнэлгийн ерөнхий захирлын 2023 оны А/165 тоот тушаалаар “Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн дотоод хяналт, шалгалтын журам” батлагдсан. 2023 онд стандартын хяналтыг нийт 22 төв, тасаг, албадуудыг, 2024 онд 28 төв, тасаг, албадуудыг хамруулан зохион байгуулж 100 гаруй үл тохирлыг илрүүлэн ажлын байран дээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
	6.4 Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн нэгжүүдийн түвшинг хадгалж, хөгжүүлэх	Сайжруулалтын үнэлгээний тайлан, гарсан үр дүн, баримтжуулсан мэдээлэл	УНТЭ нь ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр зөвлөх үйлчилгээний компани болох “УАЙ ЭС КОНСАЛТИНГ” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажилласан бөгөөд 2023 оны 12 дугаар сард Мон Майнинг Сертификейшн ХХК-тай баталгаажуулалтын үйлчилгээний гэрээ байгуулан 12 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд баталгаажилтын аудитад хамрагдан 3 жилийн хугацаатай итгэмжлэгдсэн. Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн нэгжүүдийн түвшинг хадгалж хөгжүүлэхийн тулд, тогтмол сайжруулалт хийхийн тулд эмнэлгийн хэмжээнд 32 стандартын аудит бэлтгэсэн. Эмнэлгийн ерөнхий захирлын 2023 оны А/165 тоот тушаалаар “Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн дотоод хяналт, шалгалтын журам” батлагдсан. 2023 онд стандартын хяналтыг нийт 22 төв, тасаг, албадуудыг, 2024 онд 28 төв, тасаг, албадуудыг хамруулан зохион байгуулж 100 гаруй үл тохирлыг илрүүлэн ажлын байран дээрх мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
		Хяналт, үнэлгээний тоо, тайлан, гарсан үр дүн	УНТЭ-ийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албанаас жилийн турш өвчний түүхийн

	6.5 Эмчилгээний чанар, аюулгүй байдлын процесст тогтмол хяналт тавьж, хариу рефорт илгээж, тасралтгүй сайжруулалтыг хийх		хяналт, ижил мэргэжилтний үнэлгээ, чанарын хяналт, халдварын сэргийлэлтийн хяналт, цус цусан бүтээгдэхүүний хэрэглээнд тавих хяналт, амбулаторийн тусламж үйлчилгээний хяналтуудыг тогтмол зохион байгуулж холбогдох байгууллагуудад тайлан мэдээг хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллаж байна. Мөн гарсан алдаа зөрчлийг эмнэл зүйн албаар хэлэлцүүлэх, алдаа зөрчлийг давтагдахаас сэргийлж мэргэжил арга зүйгээр хангах, дэмжлэгт удирдлага үзүүлэх арга хэмжээг тогтмол авч байна. Тайлант хугацааны хэрэгжилт 100%
--	--	--	--

УНТЭ-ийн 2020-2024 онд хэрэгжүүлэн ажиллах стратеги төлөвлөгөө нь нийт 5 тэргүүлэх чиглэлээр 93 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж батлагдсан бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар 4 жилийн хэрэгжилт 85.4%-тай байна.

ТАЙЛАН ХЯНАСАН: ЗАХИРЛЫН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Ц.АМАРЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН: ЗАХИРЛЫН АЖЛЫН АЛБАНЫ ДХМ/ХШҮМ

Б.ЭНХТУУЛ

